



НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗАР

2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



УЛААНБААТАР ХОТ
2021.12.10

ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН....	2
1.1. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	4
1.2. Нийслэлийн засаг дарга бөгөөд улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	4
1.3. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	5
1.4. “Алсын хараа 2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт	6
1.5 Үндэсний хөтөлбөрүүд.....	6
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН	7
2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт	7
2.2. Шинэ төрлийн коронавирус /covid-19/-ийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажил	8
ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН.....	12
3.1. Дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилт	12
3.2. Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр	28
3.3 Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл.....	30
3.4 Судалгаа	34
3.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хэрэгжүүлсэн ажил	37
3.4. Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаа.....	38
3.5 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийн шийдвэрлэлт	40
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ	42
4.1. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал.....	42
ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ.....	46
5.1. Түншлэл, хамтын ажиллагаа.....	46
5.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан тухай	49
5.3 сэтгэл ханамжийн судалгаа.....	50
5.4 Дүгнэлт, Санал.....	52

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН


“Алсын Хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Мөн Монгол улсын болон Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан хөдөлмөр эрхлэлтийн талаарх холбогдох зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэн Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль, “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын дагуу байгууллагын үйл ажиллагааг төлөвлөж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийн дагуу тус тус хэрэгжилтийг тайлагнан ажиллаа.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжилтэй ажиллах хүчин бэлтгэх, төгсөгчид ажлын байрыг өөрөө бий болгоход чиглэсэн мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг дэмжих, албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулах, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээг жил бүр Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс батлан хэрэгжүүлж байна.

Тус байгууллага нь 9 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдтэй хамтран Нийслэлийн хүн амын ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг дүүрэг, хороодын онцлог, хөгжлийн чиг хандлагатай уялдуулан тэгш, хүртээмжтэй түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэн ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн статистик мэдээллүүд

График 1. Ажилгүйдлийн түвшин, хувь



Ажилгүйдлийн түвшин 2021 оны 3 дугаар улирлын байдлаар 7.4 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1 пунктээр өссөн байна.

График 2. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хувь





График 3. Ажиллах хүчний оролцооны түвшин, хувь



Үндэсний Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn/

Нийслэлийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн түвшин 48.9 хувь, ажиллах хүчний оролцооны түвшин 52 хувь байгаа нь 2020 онтой харьцуулахад хөдөлмөр эрхлэлтийн түвшин 5.8 пунктээр, ажиллах хүчний оролцооны түвшин 5.9 пунктээр тус тус буурсан байна.

Энэ нь дэлхий нийтийг хамарсан ковид-19 халдварын дэгдэлт улс орон даяар тархсантай холбогдуулан, удаа дараа хөл хорио тогтоосонтой холбоотой байна.

1.1. ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх 2 зорилт, 5 арга хэмжээний биелэлтийг улирал бүр гарган, дээд шатны холбогдох байгууллагуудад тайлагнан ажиллалаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн дундаж **98%** байна.

Арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хангасан байдал:

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
1	Хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн шинэчилж, бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалт бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	90%
2	“Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгоно.	100%
3	Орлого багатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	100%
4	Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа Монгол иргэдийг дэмжих, эх орондоо эргэн ирж ажиллаж хөдөлмөрлөхөд дэмжлэг үзүүлэх хөдөлмөрийн бирж бий болгоно.	100%
5	Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана.	100%
Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь		98%

1.2. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр тусгагдсан 2 зорилтын 8 арга хэмжээний хэрэгжилтийг гарган, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсний дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. Хөтөлбөрийн хэрэгжилт **88.1%** буюу “тодорхой үр дүнд хүрсэн” үзүүлэлттэй байна.

Арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хангасан байдал:

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
1	Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан, гарааны бизнес эрхлэлтийг дэмжинэ.	90%
2	Оюутан, залуучуудыг цагаар ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлэн, суралцах хугацаанд нь хөдөлмөр эрхлэлтийн түүхтэй болгоно.	90%

3	Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн систем болон цахим хөдөлмөрийн биржийг хөгжүүлэх замаар үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	90%
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тохирсон цагийн болон түр ажлын байрыг нэмэгдүүлнэ.	90%
5	Мэргэжлийн болон давтан сургалтад иргэдийг хамруулан, тохирох ажлын байранд зуучилна.	90%
6	Бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын цагийг богиносгох замаар байгууллагын урсгал зардлыг бууруулах мэдээлэл, нөлөөллийн аян зохион байгуулна.	90%
7	Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа иргэдийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээ мэдээллээр хангах, ажлын байранд зуучлах өдөрлөгийг тогтмол зохион байгуулна.	90%
8	Ажил олгогч, аж ахуй нэгж байгууллагуудад зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна.	90%
Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь		88.1%

1.3. НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хүрээнд 2 зорилтын 7 арга хэмжээний хэрэгжилтийг гарган Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст тайлагнан ажиллалаа. Хэрэгжилтийн дундаж **87.1%**-тай байна.

Арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хангасан байдал:

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
1	Шинээр ажлын байр бий болгосон ажил олгогчдыг дэмжин, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлсэн байна.	90%
2	“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийг олон улсын жишигт нийцүүлж, бүсчилсэн байдлаар хөгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг хүргэсэн байна.	90%
3	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт, мэргэжлийн болон давтан сургалтыг бүрэн дунд түүнээс доош боловсролтой, мэргэжилгүй, ажлын туршлагатай залуу ажиллах хүчинд чиглүүлэн зохион байгуулсан байна.	90%
4	Оюутан залуучуудын цагийн ажил хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	90%
5	Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан гарааны бизнес эрхлэлтийг дэмжинэ.	90%
6	Бичил бизнес эрхлэгчдийг жижиг бизнес эрхлэгч болгох суурь нөхцөл бүрдсэн байна.	70%

7	Албан бус эдийн засгийн салбарт ажиллагсдыг албан салбарт шилжүүлж зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн байна.	90%
Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь		87.1%

1.4. “АЛСЫН ХАРАА 2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан холбогдох 3 зорилтын 6 арга хэмжээний явцын хэрэгжилтийг гарган Нийслэлийн Засаг Даргын тамгын газар болон Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлэн ажиллаа. Явцын хэрэгжилт **87.6%**-тай хэрэгжсэн байна.

Арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хангасан байдал:

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
1	2.6.4.Ажлын байрны мэдээллийг аймаг, сум, дүүргээр гаргаж, хөдөлмөр эрхлэлтийн шилжилт хөдөлгөөнийг зохицуулна.	90%
2	“2.6.14.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжихэд чиглэсэн шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлнэ.	90%
3	3.1.14.Эхний ээлжид эмзэг бүлгийн ерхийн нэг гишүүнийг ажлын байраар хангах бодлого баримтална.	96%
4	3.1.15.Зорилтот бүлгийн ерхийн боловсролгүй, ажил эрхлээгүй ерхийн тэргүүлэгч, насанд хүрсэн гишүүдийг мэргэжилтэй ажилтан болгох бодлогын хүрээнд мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг ахиулах сургалтад хамруулна..	90%
5	3.3.14.Гарааны бизнес эрхлэгч залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлнэ.	90%
6	3.3.20.Бичил, жижиг, дунд бизнест чиглэсэн санхүүгийн урамшуулал, дэмжлэгийг нэмэгдүүлж, эрх зүйн таатай орчныг бүрдүүлнэ.	70%
Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь		87.6%

1.5 ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮД

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан холбогдох 5 үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийн дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнан ажиллалаа. Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн дундаж **92,4%** байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.1. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Хууль дээдлэх зарчмыг баримтлан үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, болон өөрийн эрхлэх асуудлын хүрээний холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Дээд газрын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг байгууллагын хэмжээнд мэдээллээр хангах, хяналтад авах, төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах байдлаар хэрэгжүүлэн ажилласан.

Оны эхэнд бодлогын болон эрх зүйн баримт бичгийн зүйл заалтыг эзэнжүүлж, тайлан мэдээ гаргах хуваарийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/121 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу гарган, Газрын даргаар батлуулан ажиллаж байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс ирүүлсэн хууль, тогтоомжийн жагсаалтын дагуу Монгол улсын 2 хуулийн 13 заалт, Засгийн газрын 2 тогтоолын 10 заалтын биелэлтийг гарган, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дээд шатны байгууллагад хугацаанд нь хүргүүллээ. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн дундаж хувь **90%** байна.

Тайлант хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай болон шинэ төрлийн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Нийслэлийн Засаг даргын А/10, А/85, А/87, А/108, А/161, А/265, А/431, А/477 зэрэг 20 захирамжийн 35 заалт, Нийслэлийн Онцгой Комиссын 01, 02, 03, 04, 05, 06, 07, 08, 09 дүгээр хурлын тэмдэглэлийн хэрэгжилтийг тус тус 7, 14 хоног тутамд гарган L-monitoring програмд оруулсан.

ХХҮЕГ-г /цаасан суурьтай/			НЗДТГ-г /L-monitoring программ/			
Засгийн газрын тогтоол	ХНХСайдын тушаал	ХХҮЕГ-ын даргын тушаал	Засгийн газрын тогтоол	НЗД-ын захирамж	НОК-ын Хурлын тэмдэглэл	Нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгавар
3/12	-	2/5	3/12	20/25	9/12	20/40
17			99			
Нийт 50 тогтоол шийдвэрийн 102 заалт						

2.2. ШИНЭ ТӨРЛИЙН КОРОНАВИРУС /COVID-19-ИЙН ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 27, 45, 91 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2021 оны А/06, А/87, А/108, А/161, А/265, А/431 дугаар захирамж, улс, нийслэлийн Онцгой комиссоос гарч буй удаа дараагийн шийдвэрүүдийг тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Тус байгууллага нь Коронавируст /Ковид-19/ цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээний хүрээнд нийт албан хаагчдыг 2021 оны 01 дүгээр сарын 29 болон 02 дугаар сарын 09-ний өдрүүдэд 2 удаа PCR шинжилгээнд нэгдсэн журмаар хамруулж, байгууллагын өрөө тасалгаа нийт 100 м.кв² талбайд 7 удаагийн давтамжтай ариутгал, халдваргүйжүүлэлтийг “Улаанбаатар ариутгал ХХК-иар хийлгэсэн.
- Албан хаагчдыг коронавирус /Covid-19/-ээс урьдчилан сэргийлэх вакцинд хамруулах зорилгоор дархлаажуулалтын талаарх хууль тогтоомж, холбогдох мэдээ, мэдээллүүдийг тухай бүр хүргэн ажилласан. 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт албан хаагчид вакцины 2 дугаар тунд 100%, 3 дугаар тунд 90% хамрагдсан.
- Нийслэлийн Онцгой байдлын албан хаагчидтай хамтран Нийслэлийн засаг даргын А/25 тоот захирамжийн дагуу Баянгол дүүргийн 6, 7, 8 дугаар хороонд үйл ажиллагаа эрхэлж буй худалдаа, үйлчилгээний байгууллагуудын QR кодоор бүртгэлжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавин, 2021 оны 01 дүгээр сарын 26-31-ний өдрийг хүртэлх хугацаанд албан хаагчид хуваарийн дагуу ажиллаж 100 гаруй албан байгууллагад хяналт хийн, холбогдох зөрчлийг арилгуулан, зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан.



- 2021 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс 22-ний өдрүүдэд Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан “Нэг хаалга нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд Сүхбаатар дүүргийн 18, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт Ковид-19 зохицуулагчаар 6 багт хуваагдан хуваарийн дагуу ажиллаж нийт 40 гаруй км талбайд хяналт, зохицуулалтын ажлыг хийж 14 хүнсний дэлгүүр, 2 сайжруулсан түлш борлуулах цэг, 2 ус түгээгүүрийн газар болон нийтийн эзэмшлийн зам талбайгаар зорчиж, үйлчлүүлж байсан нийт 508 иргэнд халдвар, хамгааллын дэглэмийг баримтлах, маск тогтмол зүүх талаар зөвлөгөө, мэдээллийг өгч ажилласан байна.



- Нийслэлийн онцгой комиссын шуурхай штабт 24 цагийн шуурхай жижүүрээр 2021 оны 04 дүгээр сард 1 албан хаагч 2 удаа ажилласан.



- 2021 оны 05 дугаар сарын 04-өөс 10-ны өдрүүдэд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7 дахь заалтыг үндэслэн коронавируст халдвар, цар тахалтай тэмцэх Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу Нийслэлийн өмчит байгууллагуудын тээврийн хэрэгслийг жолоочийн хамт дайчлан татан төвлөрүүлж ажиллуулах ажлын хүрээнд Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын 95-22УБВ улсын дугаартай старекс маркийн автомашиныг замын хөдөлгөөнд оролцох болон бэлэн байдлыг хангаж, Улс, нийслэлийн онцгой комиссоос дуудсан газар, тогтоосон хугацаанд халдвар авсан иргэдийг тээвэрлэх, шинжилгээний сорьц цуглуулах ажлыг хийсэн.



- 2021 оны А/313 дугаар захирамж, УОК-ын даргын 41 дүгээр тушаалаар батлагдсан түр журмын хэрэгжилтийг хангуулах, хяналт, шалгалт хийх ажлыг

Нийслэлийн онцгой байдлын штабын ажлын хэсгийн гишүүдтэй хамтран төвийн 6 дүүргийн хэмжээнд зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд нийслэлд үйл ажиллагаа явуулдаг 50 мэргэжлийн сургалтын байгууллагатай холбогдож, 13 сургалтын төвийн үйл ажиллагаатай танилцан, түр журмыг танилцуулан, хяналт тавьж, зөвлөгөө өгч ажилласан. Ихэнх сургалтын байгууллага нь түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд цар тахлын улмаас түрээсийн гэрээг хугацаанаас өмнө дуусгасан байсан ба мэргэжлийн сургалтын танхимын хичээл эхлээгүй, үйл ажиллагаа жигдрээгүй байна.

- Дээд газраас гарч буй захирамж, тушаал, шийдвэрийг албан хаагчдад тухай бүр шуурхай танилцуулж, нэг удаагийн амны хаалтаар ханган, ажлын байрандаа тогтмол амны хаалт хэрэглэх, гар барин мэндчилэхгүй байх заавар, зөвлөмж өгч, байгууллагын хэмжээнд шаардлагатай амны хаалт, гар ариутгагч болон ариутгал халдваргүйжүүлэлтийн 700,0 мянган төгрөгийн бараа, материалыг худалдан авсан.
- Мөн байгууллагын албан хаагчид болон тус байгууллагаар үйлчлүүлэгчдийн биеийн халууныг шалгаж нэвтрүүлэх, гарыг ариутгах, амны хаалтын хэрэглээг хэвшүүлэх, халдваргүйтгэлийг 2 цаг тутам хийх, иргэн үйлчлүүлэгчдийг нэг дор олноор байлгахгүй байх зэрэг мэргэжлийн байгууллагын гаргасан зөвлөмж, шаардлага, стандартыг мөрдөн ажиллаж, үйлчлүүлэгчдэд зориулан амны хаалттай үйлчлүүлэх тухай санамж байршуулан, гар ариутгах нөхцөлийг бүрдүүлсэн.
- Улсын Онцгой комисс болон Нийслэлийн онцгой комиссын тушаал захирамжийн дагуу байгууллагын 0-2 хүртэлх насны хүүхэдтэй 3 албан хаагчийг албан үүргээ гэрээр гүйцэтгэх боломжоор ханган, утсан харилцаа холбоогоо 24 цагаар нээлттэй байлгах, цаг үеийн болон хугацаатай мэдээ, тайланг тухай бүр гаргаж, үр дүнг тайлагнан ажиллахыг үүрэг болгосон.
- Түүнчлэн Нийслэлийн Засаг даргын Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэргийг сунгах тухай, Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, ажил эрчимжүүлэх тухай 108, 161, 265, 431, 477 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган, албан хаагчдыг 10-30%-иар ажиллах 4 удаагийн хуваарийг гарган мөрдөн ажилласан.

Шинэ төрлийн коронавирус /Covid-19/-ийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, ажлын хүрээнд байгууллагын үйл ажиллагаанд цахим системийг ашиглах тухай дээд шатны байгууллагаас өгч буй зөвлөмж, чиглэлийн дагуу дараах арга хэмжээг авч ажиллав. Үүнд:

1. <https://ework.hudulmur-halami.gov.mn/>, <https://erp.ulaanbaatar.mn/> системийг ашиглан, цахим хэлбэрээр албан хаагчдад үүрэг даалгаврыг өгч, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.

2. Хурал, уулзалтыг UB ERP, Zoom зэрэг онлайн хурлын систем ашиглан цахимаар зохион байгуулахаар төлөвлөн, дээд газраас зохион байгуулж буй хурал, уулзалтад цахимаар оролцож байна.


3. Дэлхийн ЭМБ, ЭМЯ-аас гаргаж буй тархалт, шинэ төрлийн коронавирус /Covid-19/-ийн халдвараас урьдчилан сэргийлэх тухай зөвлөмж, сэрэмжлүүлэг, гарын авлага, зурагт хуудсыг байгууллагын <http://ubbirj.ub.gov.mn/> цахим хуудас болон салбар нэгжийн facebook хуудсаар тогтмол сурталчилж байна.

Тус байгууллагын нийт албан хаагчид Монгол улсын Засгийн газрын 91 дүгээр тогтоолоор Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг, халдварын тархалтын “Улаан түвшинд” шилжүүлсэнтэй холбогдуулан нийслэлийн засаг

даргын 2021 оны А/265 тоот захирамжийн дагуу 2021.04.10-05.08-ны өдрүүдэд гэр гэртээ байж, өөрсдийгөө болон гэр бүлээ Ковид-19 цар тахлаас сэргийлж, цахимаар болон утсаар албан ажлаа хийж гүйцэтгэсэн.

Эрүүл мэндийн байгууллага, улс, нийслэлийн Онцгой комиссын шийдвэр, нийслэлийн Засаг даргаас гаргасан зөвлөмжийн дагуу Эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмж уриалга бүхий зурагт хуудас тараах материалыг www.ubbij.ub.gov.mn цахим хуудсанд байршуулж, НЗДТГ-аас цаг үеийн мэдээ, мэдээллийг хүргэх “Нийслэлийн мэдээ” пэйж хуудсанд өдөр тутам байгууллагын албан хаагчид өөрсдийн хувийн пэйж хуудсаар дамжуулан 180 мэдээг шейрлэж, 577 лайк, 200 шейр цуглуулсан байна.

- Нийслэлийн Онцгой комиссын даргын баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас коронавирусын халдварын үеийн тусламж үйлчилгээнд дэмжлэг үзүүлэн ажиллах хуваарь”-ийн дагуу Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны өрхийн эмнэлэгт Ковидын эмийн багцын савлах, хүргэлтийн ажилд 4 албан хаагч ээлжээр ажилласан.



- Хан-Уул дүүргийн шуурхай штабын тусламж, зөвлөгөөний тусгай дугаарын оператораар хэлтсийн 2 мэргэжилтэн 10,11 дүгээр сард ажилласан.



ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1. ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, хөгжлийн бодлогын бусад баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилттой уялдуулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг нийслэлийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж, үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийг чанд мөрдөж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллалаа.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

Тайлант хугацаанд Нийслэлийн хэмжээнд **6961** ажлын байр шинээр бүртгэгдэж, **19667** ажлын байрны захиалга авч, **14290** ажил хайгч иргэнийг бүртгэн, **11870** иргэнийг тохирох ажлын байранд зуучилснаас **10121** нь буюу **85.2** хувь нь ажилд орсон байна.

Тус байгууллагын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Дүнжингарав салбарт байрлах “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв” нь “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавих шаардлага” MNS:6620-2016 стандартын дагуу иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг нэг цэгээс үзүүлж байна. 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар 711 ажил олгогчдын **7966** ажлын байрны захиалгыг төвлөрүүлж, давхардсан тоогоор нийт **29464** иргэн, ажил олгогчид дараах байдлаар үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд:

- Бүртгэсэн ажил хайгч иргэн **2455**
- Ажлын байранд зуучилсан иргэн **5701** /үүнээс ажилд орсон **3961**/
- Цахим үйлчилгээнд хамрагдсан иргэн **3123**
- Цахим өдөрлөгт хамрагдсан иргэдийн тоо **273**
- Дундын оффисоор үйлчлүүлсэн иргэн **656**
- Хүүхдийн өрөөгөөр үйлчлүүлсэн иргэн **112**
- Шийдвэрлэсэн санал хүсэлт **1059**
- АМЧБО бүлгийн сургалтад хамрагдсан иргэн **2181**
- АМЧБО ганцаарчилсан зөвлөгөөнд хамрагдсан иргэн **4991** тус тус байна.

Тайлант хугацаанд үзүүлсэн хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг өмнөх оны мөн үетэй харьцуулан харуулбал:

№	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	2020	2021
1	ХЭДТ-өөр үйлчлүүлсэн иргэн	28974	29464
2	Бүртгэсэн ажил хайгч иргэн	4316	2455
3	Ажлын байранд зуучилсан иргэн	7994	5701
4	Ажилд орсон иргэн	3423	3961
5	Төвлөрүүлсэн ажлын байрны захиалга	6168	7966
6	Цахим үйлчилгээнд хамрагдсан иргэн	3727	3123
7	Хүний нөөцийн бүрдүүлэлтийн ажлын ярилцлага	2275	768
8	Дундын оффисоор үйлчлүүлсэн иргэн	1072	656


9	Хүүхдийн өрөөгөөр үйлчлүүлсэн иргэн	410	112
10	Шийдвэрлэсэн санал хүсэлт	3100	1059
11	АМЧБО бүлгийн сургалтад хамрагдсан иргэн	1229	2181
12	АмБЧО ганцаарчилсан зөвлөгөөнд хамрагдсан иргэн	3434	4991

2020 оны мөн үетэй харьцуулахад цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан зарим төрлийн үйлчилгээний үзүүлэлт буурсан ч ажлын байрны захиалга болон ажилд орсон иргэдийн тоон үзүүлэлт өсөлттэй байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвөөр үйлчлүүлсэн **7172** иргэнд үзүүлсэн ба ганцаарчилсан зөвлөгөө мэдээлэлд **4991** иргэнийг, бүлгийн сургалтаар **2181** иргэнийг хамруулсан байна.

Үйлчилгээнд хамрагдсан нийт иргэдийн боловсролын түвшин, зөвлөгөө, мэдээллийн төрөл, насны бүлгээр эзлэх хувийг дэлгэрэнгүй харуулбал:



Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 71% нь бүрэн дунд боловсролтой, 25-34 насны залуучууд эзэлж байгаа бөгөөд дийлэнх нь хөдөлмөр эрхлэлтийн талаар зөвлөгөө мэдээлэл авсан байна.

Мөн “Төвшин сайхан төв”-ийн хог ангилан ялгадаг зорилтот бүлгийн 16 эмэгтэйд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтыг 2021 оны 04 болон 05 дугаар саруудад 2 үе шаттай зохион байгуулсан.



“Ажил мэргэжил судлалын үндэсний хүрээлэн”-тэй хамтран ажиллах санамж бичгийг 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдөр “Шилжин ирэгсдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар тэдэнд нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх төр болон хувийн хэвшлийн байгууллагуудын сүлжээг буй болгож чадавхыг бэхжүүлэх зорилгоор байгуулсан. Тус санамж бичгийн хүрээнд ажил олоход хүндрэлтэй **45** иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээг нэг дороос 2021 оны 06 дугаар сараас 11 дүгээр сарын хугацаанд үзүүлэн ажилласан. Хамрагдсан иргэдийн **90** хувь нь ажлын байранд зуучлагдсан байна.



Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Төрийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэх нь” “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээний танилцуулга” сэдвээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтыг 2021 оны 03, 04, 05, 10 дугаар саруудад үе шаттайгаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй **73** иргэн болон үйлчилгээ үзүүлж буй албан хаагчдыг хамрууллаа.



Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийн хүрээнд нийслэлийн хэмжээнд **752** оролцогч дадлагажих үйл ажиллагаанд хамрагдсан ба тус дадлагажигчдад хөдөлмөр эрхлэлтийн зөвлөгөө мэдээллийг ганцаарчилсан хэлбэрээр биечлэн болон утсаар өгч ажилласан.

Ажилд зуучлах үйлчилгээ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв нь ажилд зуучлах үйлчилгээг чанартай, түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх, иргэд ажил мэргэжлийн ирээдүйгээ зөв баримжаалж, сурч, ажиллаж, хөгжих боломж, нөхцөлийг бүрдүүлэх, улмаар хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх зорилгоор үйл ажиллагаагаа нэг цэгээс цогцоор үзүүлэн ажилладаг.


Ажилд зуучлах үйлчилгээний хүрээнд **711** ажил олгогч байгууллагатай хамтран ажиллаж, **7966** ажлын байрны захиалгыг төвлөрүүлж, **2455** ажил хайгч иргэнийг шинээр

бүртгэн, **5701** иргэнд тохирох ажлын байрыг санал болгосноос **3961** иргэн буюу **69.4** хувь нь ажилд орсон байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд Мөнгөн гану ХХК, Баялаг энержи ресурс ХХК, Кредит банк, Централ экспресс ХХК-иас хөгжлийн бэрхшээлтэй иргэний **216** нээлттэй ажлын байрны захиалга авч, **187** иргэнийг бүртгэж, **44** иргэнийг ажлын байранд зуучилснаас **39** ажилд орсон.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвийг байгуулав.

Швейцарын хөгжлийн агентлаг Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслөөс Хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг залуучуудад хүргэх, хамтран ажиллах талаар санал солилцох уулзалтыг 2021 оны 05 дугаар сард зохион байгуулж, уулзалтын үр дүнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих загвар төвийг байгуулахаар болсон. Үүний хүрээнд загвар төвийн тоног төхөөрөмж, засвар, тавилга эд хогшлын мэдээллийг гарган төслийн захиргаанд хүргүүлсний дагуу Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвийг Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дэргэд 2021 оны 11 дүгээр сарын 25-нд байгуулж, нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа.



Хамтран ажиллах гэрээний дагуу **250** залуучуудад хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг 2021 оны 12 сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 сарын 01-ний хугацаанд үзүүлэхээр тусгасан.

Мөн загвар төвд шаардлагатай тавилга, компьютер хэрэгсэл, засварын ажилд төслөөс нийт 28 орчим сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, төвийн ажилтнуудыг шат дараалсан сургалт, чадавх бэхжүүлэх арга хэмжээнд хамруулсан ба ахлах мэргэжилтэн Н.Одонтуяа, мэргэжилтэн Х.Орхончимэг нар залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх мастер багшаар сургагдаж, гэрчилгээ авсан.

Түүнчлэн, залуучууд хоорондын хамтын ажиллагааг дэмжих зорилгоор бүлгийн модуль сургалтыг нийт 4-5 долоо хоногийн хугацаатай хэрэгжүүлэх бөгөөд энэ явцад ажил хайгч залуу өөрийгөө илүү танин мэдэх, ажил олгогчтой холбоо тогтоох, ажлын ярилцлагад амжилттай орох ур чадвар, чадамжаа хөгжүүлэх боломжтой болно. Сургалтад хамрагдсан залуус ажил хайх, олохтой холбоотой өөрийн туршлага, сургамжаас бүлгийн бусад гишүүдтэй хуваалцах боломж мөн бүрдэх юм. Түүнчлэн хувиараа хөдөлмөр эрхлэх, бизнес эрхлэх сонирхолтой залуучуудад тусгайлан зориулсан модуль сургалтад хамрагдаж, бизнес санаагаа олох, хөгжүүлэх, төлөвлөх чиглэлээр мэдлэгтэй болох боломжтой.

Шинэлэг үйлчилгээний зорилтот бүлэг бол 15-34 насны залуучууд бөгөөд үүнд Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, их дээд сургуулийн оюутан, төгсөгчид, ажил хайгч бүртгэлтэй болон бүртгэлгүй залуус хамрагдах боломжтой. Одоогийн байдлаар төслийн хүрээнд тус Загвар төвийг 21 аймаг, 9 дүүрэгт тус тус байгуулж, шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна.

Ажлын байрны өдөрлөг, яармаг

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг боловсронгуй болгох, шат дамжлагыг багасгах зорилгоор ажил олгогчидтой хамтран хүний нөөцийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг ажлын байрны өдөрлөг зохион байгуулах болон онлайн зуучлалын хэлбэрээр хэрэгжүүлсэн.

Ажлын байрны өдөрлөг нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн ажил олгогчийн танхимд ажил олгогч, ажил хайгч иргэд хооронд анхан шатны ярилцлага шууд хийж, ярилцлагын үр дүнг иргэдэд тухай бүр өгч, чирэгдэл багатай зохион байгуулдгаараа онцлог юм. Жилийн эцсийн байдлаар ажлын байрны өдөрлөг, яармагийг холбогдох газруудтай хамтран 5 удаа зохион байгуулсан. **Үүнд:**


1. 2021 онд шинэ төрлийн коронавирусийн халдвар дэлхий дахинд тархаж, Улсын онцгой комиссын шийдвэрээр олон нийтийг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулахыг тодорхой хугацаагаар хязгаарласны дагуу их, дээд сургууль болон мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгч оюутан, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээ, зөвлөгөө, мэдээллийг нэг дороос үзүүлэх, цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан ажил олгогч байгууллагуудын хүний нөөц бүрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилготой ЦАХИМ ТӨГСӨЛТ- ЦАХИМ АЖЛЫН БАЙР” өдөрлөгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол шинжлэх ухааны яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, "Эйч Ар клуб" ТББ - тай хамтран CAREER EXPO платформ дээр 2021 оны 06 дугаар сарын 07,08-ны өдрүүдэд зохион байгуулсан.



Тус өдөрлөгт 184 ажил олгогч байгууллагын 2129 нээлттэй ажлын байрны мэдээллийг нэг дороос хүргэсэн. Цахим платформоор дамжуулан 1051 төгсөгчид ажил хайгчаар бүртгүүлсэн ба 1019 төгсөгч цахимаар цаг товлон, ажлын шууд ярилцлагад орсон. Мөн 88 Их, дээд сургууль, Политехникийн коллеж, МСҮТ-ийн төгсөгчид бүртгэгдсэн.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас дэвшүүлсэн “ХАЛАМЖААС ХӨДӨЛМӨРТ” зорилтын хүрээнд “ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ХАМТДАА-ХӨДӨЛМӨРИЙН ЦАХИМ ЯАРМАГ-2021” арга хэмжээг Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Монголын үндэсний худалдаа аж


үйлдвэрийн танхим, НҮБ-ын дэргэдэх Шилжилт хөдөлгөөний байгууллага, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Эйч Ар Клуб ТББ хамтран 2021 оны 05 дугаар сарын 08-24-ний өдрүүдэд expomongolia.org платформоор зохион байгуулан ажиллалаа.



Энэхүү хөдөлмөрийн цахим яармаг нь Цар тахлын эсрэг хамтдаа-Зохистой хөдөлмөр эрхлэлт, Халамжаас хөдөлмөрт дэд сэдвүүдийн хүрээнд цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан www.expomongolia.org платформоор дамжуулан виртуал талбарт анх удаа зохион байгуулагдсанаараа онцлог юм.

Тус арга хэмжээний хүрээнд ажил хайгч иргэд, оюутан, залуучууд, гадаадад их дээд сургууль төгссөн болон ажиллаж, амьдарч байгаад эх орондоо ирсэн иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээ, цахим хурлууд, 183 ажил олгогч байгууллагын 2126 сул чөлөөтэй ажлын байрны мэдээ, мэдээллүүдийг нэг дороос хүргэсэн. Цахим платформоор дамжуулан 273 ажил хайгч иргэд болон ажил олгогчид цахимаар цаг товлон, ажлын шууд ярилцлагыг зохион байгуулан ажилласан.

Платформын ерөнхий зохион байгуулалт



Цахим лобби

Үзэсгэлэнгийн танхим


Цахим хурлын танхим

Цахим өдөрлөгийн хугацаанд www.expomongolia.org/careerexpo платформд цахим үзэсгэлэнгийн танхимд давхардсан тоогоор 15515 хандалт, цахим сургалт семинарын хүрээнд 1697 хүн, цахим үзэсгэлэнгийн танхимд 183 ажил олгогч 2129 нээлттэй ажлын байрыг цахимаар танилцуулж, цахим үзэсгэлэнгийн танхимд 273 ажил хайгч иргэн мэдээллээ байршуулан оролцсон байна.

Мөн цахим яармагийн мэдээлэл, хүндэт зочдын мэндчилгээ бүхий үндсэн 3 видеог платформд байршуулж, статистик мэдээллийг өдөр бүр өссөн дүнгээр болон тухайн өдрөөр харагдахаар байршуулж ил тод мэдээлсэн. Түүнчлэн яармагийн хөтөлбөрийг 2 өдрөөр иргэдэд харагдахуйц 2 төрлөөр байршуулж ажилласан.

Эрүүл мэндийн салбар, худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл, уул уурхай, барилга дэд бүтцийн чиглэлийн ажил олгогчийн хандалт өндөр байсан ба үйлдвэрлэл, үйлчилгээ, барилга угсралт, уул уурхайн салбаруудын нээлттэй ажлын байр түлхүү зарлагдсан нь өмнөх жилүүдийн ажлын байрны өдөрлөг яармагтай адил байна. Тиймээс тус салбаруудад шилжилт хөдөлгөөн ихээр хийгдэж, ажиллах хүчний хэрэгцээ тогтмол өсөлттэй байгаа нь харагдлаа.

Оролцсон ажил олгогчдыг үйл ажиллагааны чиглэлээр харуулбал:




Хөдөлмөрийн яармагийн онцлог, давуу тал

- Виртуал орчинд анх удаа
- Ажил олгогч болон ажил хайгч иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэсэн
- Ажил олгогчид байгууллагаа сурталчлах боломжоор хангасан
- Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулсан
- Олон нийтэд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, төсөл хөтөлбөр, хууль тогтоомжийг нэг дороос үзэх, мэдээлэл авах боломжоор хангасан.

Яармагийн үйл ажиллагааг хааж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа үг хэлж, үр дүнг олон нийтэд цахимаар танилцуулсан.



Үзэсгэлэнд оролцогч ажил олгогчид



Тус арга хэмжээний хүрээнд ажил хайгч иргэд, оюутан залуучууд, гадаадад их дээд сургууль төгссөн болон ажиллаж, амьдарч байгаад эх орондоо ирсэн иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээ, цахим хурлууд, **183** ажил олгогч байгууллагын **2129** сул чөлөөтэй ажлын байрны мэдээ, мэдээллүүдийг нэг дороос хүргэсэн. Цахим

платформоор дамжуулан **273** ажил хайгч иргэд болон ажил олгогчид цахимаар цаг товлон, ажлын шууд ярилцлагад **150** ажил хайгч иргэн хамрагдсан байна.

3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдаж ур чадвар эзэмшсэн иргэд, “Оролцоо” төсөлд хамрагдсан залуучууд, нийгмийн халамжийн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдсан хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэд, БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаад нутаг буцаж ирсэн иргэдэд хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого, арга хэмжээ, сурталчлах, зөвлөгөө мэдээллээр хангах, ажилд зуучлах, хөдөлмөр, халамжийн нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран “ХАЛАМЖААС-ХӨДӨЛМӨРТ” хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг Мишээл экспо олон улсын үзэсгэлэнгийн төвд 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгууллаа.



Тус өдөрлөгт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа газар, хэлтсүүд, 51 ажил олгогч байгууллага, 15 хөдөлмөрийн хувийн бирж оролцож хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг иргэд олон нийтэд нэг цэгээс хүргэж ажилласан. Арга хэмжээг нээж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Л.Дашдэмбэрэл нар үг хэллээ. Өдөрлөгөөр дараах үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, гадаадад ажиллах хүч гаргах үйл ажиллагаа, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагддаг иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагуудад танилцуулах, сурталчлах. */хэвлэмэл материал, видео анимейшн, шторк/*
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, үйлчилгээ, арга хэмжээ, хөдөлмөрлөх эрхийн талаар иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх, сурталчлан таниулах зөвлөмж, зурагт хуудас, хэвлэмэл материал түгээх.
- Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах чиглэлээр видео call, нээлттэй утас, саналын хайрцаг ажиллуулах, ажлын ярилцлага хийх.
- Иргэдэд нээлттэй ажлын байрны захиалгыг танилцуулах, ажилд зуучлах, бүртгэл мэдээллийн үйлчилгээг зохион байгуулах.
- Иргэний өмнөх мэдлэг ур чадварыг үнэлэх, баталгаажуулах, гэрчилгээ олгох ажил, үйлчилгээг танилцуулах, бүртгэлд хамруулах.
- Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн гишүүн, иргэнд нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, ажлын байранд зуучлах.

Арга хэмжээний хүрээнд нийт **4530** ажлын байрны захиалга танилцуулж, **2396** иргэнд хөдөлмөр эрхлэлтийн зөвлөгөө мэдээлэл өгч, ажил хайгч **1621** иргэнийг бүртгэн **355** иргэнийг тохирох ажлын байранд зуучилсан байна. Нийт давхардсан тоогоор **10131** иргэнд хөдөлмөр, халамжийн үйлчилгээг нэг цэгээс үзүүлсэн.



4. Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, төрийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй болгох зорилтын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/746 дугаар захирамжаар нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд, Захирагчийн харьяа газар, инженерийн хангамжийн байгууллагуудын үйл ажиллагааг танилцуулах, сурталчлах “Нээлттэй хаалганы өдөрлөг 2021” үйл ажиллагаа 10 дугаар сарын 02-ний өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан ба тус байгууллага нь иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг үзүүлж ажилласан.



5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах, хувиараа үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор 2021 оны 10 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. Тус арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 18 иргэн оролцож нийт 1136000 төгрөгийн бараа бүтээгдэхүүний борлуулалт хийсэн үр дүнтэй арга хэмжээ боллоо.




Хүний нөөцийн бүрдүүлэлт, өдөрлөг

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн ажил олгогчийн танхимд ажил олгогч, ажил хайгч иргэд хооронд анхан шатны ярилцлага шууд хийж, ярилцлагын үр дүнг иргэдэд тухай бүр өгч, чирэгдэл багатай зохион байгуулдгаараа онцлог юм. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвөөр дамжуулан ажил олгогчийг дэмжих зорилгоор Хүний нөөцийн бүрдүүлэлтийн аяныг 2021 оны 08 дугаар сарын 23-ны өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хугацаанд **18** удаа зохион байгуулсан. Үүнд:

- Зарласан ажлын байр **1132**
- Ажлын ярилцлагад орсон иргэн **768**
- Тэнцсэн ажилд орсон иргэн **549**
- Тэнцээгүй иргэн **114**
- Ажиллах хүчний нөөцөд бүртгэгдсэн иргэн **105**

Үүнээс 4 удаад нь орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчийг оролцуулж, **154** нээлттэй ажлын байрыг танилцуулж, хөдөө орон нутагт ажиллах боломжтой **147** ажил хайгч иргэнийг ажлын шууд ярилцлагад оруулж, **109** иргэн тэнцэж, хөдөө орон нутагт ажиллах байнгын ажлын байраар хангагдсан байна. Өдөрлөгийн талаарх мэдээллийг Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын цахим хуудсанд тогтмол мэдээлж, ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагыг сурталчлан ажилласан ба мэдээллийг **53498** иргэн үзсэн байна.



НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙН ГАЗАР **SANSAR**
SUPERMARKET

**НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРНЫ
ӨДӨРЛӨГТ УРЬЖ БАЙНА.**

- НЯРАВ
- КАСС
- ХУДАЛДАГЧ
- УТГАГЧ
- КАМЕР ХЯНАГЧ
- ХАМГААЛАГЧ
- САНТЕХНИКЧ
- ЦАХИЛГААНЧИН
- ТОГООЧ
- АЧИГЧ
- ҮЙЛЧЛЭГЧ
- ЖИМС САВЛАГЧ

НИЙСЛЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН
ТӨВИЙН ДҮНЖИНГАРАВ САЛБАРТ БАЙРЛАХ
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТӨВД
2020.09.23-НЫ ӨДРИЙН 10:00-17:00 ЦАГТ БОЛНО.

Дэлгэрэнгүй мэдээллийг: 7511-1896

Онлайн зуучлалаар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд бүртгэлтэй ажил хайгч иргэдийн мэдээллийг ажил олгогч байгууллагад цахим хэлбэрээр илгээж, ажлын ярилцлагад хамруулах замаар онлайн зуучлалын үйлчилгээг үзүүлдэг ба энэ нь ажил олгогч, ажил хайгч иргэн, хөдөлмөр зуучлалын байгууллага хоорондын мэдээлэл солилцох үйл явцыг хөнгөвчлөх, цаг хугацааг хэмнэх олон талын ач холбогдолтой юм. Тус үйл ажиллагааны хүрээнд нийт **3105** иргэний мэдээллийг ажил олгогч **173** байгууллагад илгээж, санал болгосон байна.

Бүртгэл, мэдээлэл

Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг улсын хэмжээнд ашигладаг <http://lmis.gov.mn/> болон Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын <https://job.opensoft.mn/> бүртгэлийн системд тухай бүр оруулж бүртгэсэн ба тус системд цахим үнэмлэх, хурууны хээ уншигч төхөөрөмжүүдтэй холбосон нь төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад түргэн шуурхай үйлчлэх боломжоор хангагдсан.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хөнгөвчлөх зорилгоор ажил хайгч иргэн, ажил олгогчид зориулан Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын <https://job.opensoft.mn/> бүртгэлийн системтэй холбосон **UB JOB** гар утасны аппликейшнээр **123** ажил хайгч иргэн бүртгүүлж, үйлчилгээ авсан байна.

Байгууллагын албан ёсны www.ubbirj.ub.gov.mn цахим хуудас, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв” болон “Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар” цахим хуудсаар **652188** иргэнд, **131896** тусгай дугаарын www.smsservice.opensoft.mn/ үйлчилгээгээр **21590** иргэнд нийт **659659** иргэнд хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээ, мэдээллийг хүргэсэн байна. Энэхүү үйлчилгээ нь хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, иргэд хоорондын эргэх холбоог сайжруулах, механик ажиллагааг багасгахад оновчтой шийдэл болж байна.

Хөдөлгөөнт бирж

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, алслагдсан дүүрэг, хороодын иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, зөвлөгөө өгөх, ажилгүй иргэдийг бүртгэх, ажилд зуучлах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг нэг дороос хүргэх зорилгоор “Хөдөлгөөнт бирж”-ийг 5 удаа буюу СХД-ийн 26-р хороо, ХУД-ийн 7-р хороо, БЗД-ийн 28-р хороо, ЧД-ийн 12-р хороо, БГД-ийн 23-р хороонд 2021 оны 09 дүгээр сард зохион байгуулж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд ажил олгогчоос ирүүлсэн нээлттэй ажлын байрыг танилцуулж, **500** гаруй иргэдэд мэдээлэл хүргэн, танилцуулга материал тарааж, **220** иргэнд ажлын байр санал болгож, зөвлөгөө өгч ажилласан.



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭ

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс 2021-2022 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 5 хөтөлбөр, 2 төсөл баталсан. Тус байгууллага нь нийслэлийн хэмжээнд 3 хөтөлбөрийн 5 арга хэмжээг дүүргүүдийн ХХҮХ-тэй хамтран 18.0 мянгаас доошгүй иргэнийг хамруулан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 904,000,000 төгрөг зарцуулан ажиллаа. **Үүнд:**

- “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн Оюутан, залуучуудыг цагийн ажилд зуучлах; Шилдэг “Старт ап” залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох
- “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-ийн Хөдөлмөр эрхлэлтийн танхимын сургалт зохион байгуулах; Хөдөлмөрт бэлтгэх /АМЧБО/
- “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийн Нийтийг хамарсан ажил зохион байгуулах; Гэрээт малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлсэн.


Оюутан, залуучуудыг цагийн ажилд зуучлах арга хэмжээ

Тус хөтөлбөрийн зорилго нь залуучуудад хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг үзүүлэх, хөдөлмөрт бэлтгэгдэх, ажлын дадлага туршлага хуримтлуулах, цалин орлоготой болох, аж ахуй эрхлэх бүтээлч шинэлэг санал санаачилгыг дэмжихэд оршино.

Энэ онд 7000 иргэнийг цагийн ажилд зуучлах арга хэмжээг Цагийн ажлын бирж болон оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 18 төв, хувийн хөдөлмөрийн биржтэй хамтран хэрэгжүүлэхээр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, ажиллаж тайлант хугацаанд цагийн ажил хийх хүсэлтэй 6726 оюутан, залуучуудыг бүртгэж, 454 ажил олгогч, аж ахуй нэгж, байгууллагын 6098 цагийн ажлын байрны захиалга хүлээн авч, 6048 оюутан залуучуудыг ажилд зуучилж, түр ажлын байраар хангасан.

Мөн Оюутан, залуучуудад зориулсан зуны амралтаараа хөдөлмөрт бэлтгэгдэх, ажлын дадлага туршлага хуримтлуулах, цалин орлоготой болох нээлттэй ажлын байруудыг танилцуулах арга хэмжээг “Цагийн ажлын бирж” цахим хуудсаар дамжуулан 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан.

Өмнөх онтой харьцуулбал



Графикаас харахад: 2020 оны мөн үеийнхтэй харьцуулахад ажил олгогчийн тоо 1.8 хувиар буурсан, ажлын байрны захиалгын тоо 3.3 хувиар, түр болон цагийн ажлын байранд зуучилсан оюутан, залуучуудын тоо 3.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Цагийн ажлын байр бий болгож байгаа хувийн хэвшлийн байгууллагууд тэдний үйл ажиллагаа үйлдвэрлэлийн орчныг тухайн мэргэжлээр суралцагч оюутан, залуучуудад танилцуулах, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл түүнд тавигдах шаардлагыг үзүүлэх, үйлдвэрлэлийн дадлага хийх боломжоор хангах, цагийн ажлын байранд зуучлах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилготой “Job tour 2021” аяллыг нийт 5 удаа зохион байгуулж 125 оюутан залуусыг хамруулсан.



Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 35 дугаар тогтоолын дагуу намрын ургац хураалтын ажилд 37 ажил олгогч байгууллагын 3134 ажлын байрны захиалгыг хүлээн авч, ажиллах хүсэлтэй 9 сургуулийн 3110 оюутан, залуучуудыг бүртгэн, ургац хураалтын ажилд хамруулсан.



Шилдэг “Старт ап” залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн Шилдэг Старт-Ап залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг нийслэлийн хэмжээнд зохион байгуулан нийт **472** залуучуудыг бүртгэж, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг хангасан нэг дэх үе шат буюу “Гарааны бизнесээ эхлүүлэх” **72** цагийн арга хэмжээнд **309** залуучуудыг хамруулж, хоёр дахь үе шат буюу “Бэлтгэл хурдасгуур” арга хэмжээнд **62** багийн **137** залуучуудыг менторын тусламжтайгаар бизнес санаагаа хөгжүүлэх, харилцан биенээсээ суралцах үйл ажиллагааг 5 долоо хоног буюу 2021.09.02-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсан.

Арга хэмжээний 3 дахь үе шат буюу Хөрөнгө оруулагчид төслөө танилцуулах арга хэмжээг “Баянхошуу дэд төв”-д 2021.09.07-2021.09.09-ны өдрүүдэд зохион байгуулж, **42** багийн **94** залуучууд өрсөлдсөнөөс шилдэг Старт-ап **18** багийн **44** залуучууд шалгарч тус бүр 10 сая төгрөгийн дэмжлэгийг эргэн төлөх нөхцөлгүйгээр авсан. Давхардсан тоогоор **584** залуучуудыг сургалт арга хэмжээнд хамрууллаа.



Хөдөлмөр эрхлэлтийн танхимын сургалт зохион байгуулах арга хэмжээ

Ажил олоход хүндрэлтэй иргэн, ялангуяа нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай гишүүнийг хөдөлмөрт бэлтгэж, ажлын байраар хангахад хөтөлбөрийн зорилго оршино.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-ийн Хөдөлмөр эрхлэлтийн танхимын сургалтад нийт 451 иргэн хамрагдахаар хүсэлт ирүүлснээс 352 иргэн 11 мэргэжлээр 15 сургалтын төвд суралцаж, мэргэжил эзэмших, ур чадварыг ахиулах сургалтад хамрагдсан.

№	Мэргэжлийн чиглэл	Суралцагчдын тоо	Хувь
1	Гагнуурчин	6	2%
2	Гар урлал бэлэг дурсгал	37	10.5%
3	Гоо засал	57	16.1%
4	Хүнд машин механизмын оператор	41	11.6%
5	Худалдагч-касс нярав	41	11.6%
6	Оёдол	85	24.1%
7	Талх,нарийн боовчин	5	1.4%
8	Тогооч	29	8.2%
9	Үсчин	20	5.6%
10	Цахилгаанчин	4	1.1%
11	Эсгий урлал	27	8%

Нийт 451 иргэн сургалтад хамрагдахаар хүсэлт ирүүлсний 352 нь сургалтад хамрагдаж 106 нь буюу 30,1 хувь нь ажлын байртай болсон байна.

Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээ

Энэ онд тус байгууллага нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 42,0 сая төгрөгийн санхүүжилттэйгээр 150 ажилгүй иргэнийг байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй бусад нөхцөл байдлын улмаас үүссэн хор уршгийг арилгах, нөхөн сэргээх, нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд бүтээн байгуулалт хийх зэрэг ажил хийх сонирхолтой иргэдийг бүртгэн, нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээг 3 удаа зохион байгуулж, түр ажил хийх хүсэлтэй **158** оюутан, залуус, ажилгүй иргэдийг хамруулж, түр ажлын байраар хангасан.




“Гэрээт малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох” арга хэмжээ

Энэхүү арга хэмжээ нь Коронавирус (ковид-19) цар тахлын үед үйлдвэрлэл үйлчилгээ мал аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээхэд чиглэсэн барьцаагүй хүүгүй эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлж, ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд зорилготой.

Тус арга хэмжээний хүрээнд гэрээт малчин өрх, ажил олгогч малчны судалгааг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудаас авч, гэрээт малчнаар ажиллах хүсэлтэй **67** иргэн, гэрээт малчин ажиллуулах хүсэлтэй 265 малчны судалгааг нэгтгэн гаргасан.

“Гэрээт малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох” арга хэмжээний танилцуулга, мэдээллийг ubbirj.ub.gov.mn, ulaanbaatar.mn, “Нийслэлийн мэдээ” фэйсбүүк хуудас, “MGL RADIO” FM 88,3 зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан сурталчилж, ХЭДС-аас 293.400 төгрөгийг зарцуулсан.

Гэрээт малчнаар ажиллах хүсэлтэй иргэдийг нас болон боловсролоор нь авч үзвэл:



Тус арга хэмжээнд бүрэн дунд боловсролтой, 45-59 насны иргэд түлхүү хамрагдахаар бүртгүүлсэн байна.

Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдээс 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар гэрээт малчин ажиллуулах хүсэлтэй 265 ажил олгогч малчны судалгааг авч нэгтгэсэн. Үүнд:

№	Аймаг дүүрэг	Ажил олгогч малчны тоо
1	Багануур дүүрэг	25
2	Багахангай дүүрэг	1
3	Архангай аймаг	19
4	Булган аймаг	28
5	Говьсүмбэр аймаг	53
6	Дорнод аймаг	10
7	Дундговь аймаг	46
8	Өвөрхангай аймаг	16
9	Өмнөговь аймаг	28
10	Завхан аймаг-	3
11	Сүхбаатар аймаг	21
12	Төв аймаг	15

Гэрээт малчин авах хүсэлт Говьсүмбэр болон Дундговь аймгуудаас хамгийн их ирсэн байна.

Тус хөтөлбөрт хамрагдахаар бүртгүүлсэн иргэдийн 7% буюу 5 өрх нь гэрээт малчнаар ажиллах хүсэлт ирүүлсэн боловч ажил олгогч малчинтайгаа гэрээний нөхцөл тохироогүй улмаас татгалзсан.

3.2. БИЧИЛ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ, ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ НИЙСЛЭЛИЙН ХӨТӨЛБӨР

Бичил бизнес эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох зорилгоор НИТХ-ын 2014 оны 16/17 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийг нийт 150 хороонд хэрэгжүүлж, Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан 123 хадгаламж зээлийн хоршоогоор дамжуулан 3479 иргэний төсөлд **14,3** тэрбум төгрөгийн санхүүжилтийг Бичил бизнесийг дэмжих нийслэлийн сангаас 2014-2016 оны хооронд олгосон.

ҮЗҮҮЛЭЛТ	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД	НИЙТ
Иргэд байгуулсан ХЗХ	5	2	1	24	4	28	20	16	17	117
Үйл ажиллагаа явуулж байсан ХЗХ	-	-	22	4	3	4	-	-	1	34 хороо
Санхүүжилт авсан хороод	5	2	23	27	7	32	20	16	18	150
Олгосон санхүүжилт	0,4	0,2	2	2,6	0,7	3,1	1,8	1,5	1,7	14,3 тэрбум
	Шийдвэрлэсэн төслийн тоо					Санхүүжилт				
2014 он	221					939,500,000				
2015 он	2721					11,010,049,500				
2016 он	537					2,358,250,500				

Санхүүжилтийг эргэн төвлөрүүлэх ажлын талаар:

“Бичил бизнесийг дэмжих Нийслэлийн сангийн зөвлөл”-ийн 2017 оны 05 дугаар тогтоолын дагуу “Бичил бизнесийн дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд олгосон санхүүжилт буюу Бичил бизнесийг дэмжих Нийслэлийн сангийн хөрөнгийг 24-36 сарын үе шаттай буцаан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулан хэрэгжүүлж байгаа ба эргэн төлөлтийг дараах байдлаар төвлөрүүлсэн байна.

Он	Эргэн төвлөрсөн дүн	Хүүгийн орлого /төгрөг/
2015 – 2016	-	171,358,325
2017	141,000,000	133,140,452
2018	3,151,760,001	125,551,242
2019	2,180,011,838	68,693,368
2020	833,173,176.78	34,071,189.95
2021.12.01	311,181,722	17,701,198
Нийт	6,617,126,738	550,515,755

2021 оны 12 дугаар сарын 01-ны байдлаар Бичил бизнесийг дэмжих нийслэлийн санд нийт 6,617,126,738 төгрөгийг буцаан төвлөрүүлсэн. Хэрэгжилт 45%-тай байна.


Шинээр 411 ажлын байр бий болж, 1270 ажлын байр хадгалагдан үлдсэн байна. Мөн өмгөөллийн үйлчилгээний “Файт Партнерс” ХХН-тэй хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулан хамтран ажиллаж, нийт **4,885,882,630** төгрөгийг нэхэмжлэн нэр бүхий **46** хадгаламж, зээлийн хоршоог иргэний хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн. Үүнээс:

- 5 хадгаламж, зээлийн хоршоо нь үйл ажиллагаа явуулж буй гэсэн бүртгэлтэй хаягт байхгүй шалтгаанаар шүүхээс нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж буцаасан тул хариуцагчийн хаяг тодорхойгүй үндэслэлээр шүүхээр эрэн сурвалжлуулах шийдвэр гаргуулж, цагдаагийн байгууллага эрэн сурвалжилж байна
- 19 Холбогдох нэхэмжлэлийн шаардлагыг шүүхээр эцэслэн шийдвэрлүүлсэн ба үүнээс 4 нэхэмжлэлийг ердийн журмаар буюу шүүх хуралдаанаар, 15 нэхэмжлэлийг хялбаршуулсан журмаар буюу эвлэрлийн гэрээ байгуулж шийдвэрлүүлсэн
- 2 хадгаламж, зээлийн хоршоонд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа явагдаж байна.
- Хялбаршуулсан журмаар буюу эвлэрлийн гэрээ байгуулж шийдвэрлүүлсэн 2 хадгаламж, зээлийн хоршоонд холбогдох хэрэг Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байна.

2021 онд нийт **13** хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг цуцалсан ба **19** хадгаламж, зээлийн хоршоог Иргэний хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлэн ажиллалаа.

Хадгаламж, зээлийн хоршооны гишүүдийг сургалтад хамруулсан байдал:

2014 оны 05 дугаар сарын 26-ны өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд нийт 60 гаруй удаагийн сургалтаар давхардсан тоогоор нийт 551 хадгаламж, зээлийн хоршооны 18441 иргэнд төсөл, хөтөлбөр, хууль эрх зүй, банк санхүүгийн чиглэлээр сургалт зохион байгуулж, мэргэжлийн ур чадвар олгосон байна.



Олон Улсын Хөгжлийн Агентлаг “Best” хөтөлбөрөөс зохион байгуулсан “Төсөл бичих аргачлал” цахим сургалтад 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс 25-ны өдрийн хугацаанд давхардсан тоогоор 50 хадгаламж, зээлийн хоршооны 471 иргэнийг хамруулж, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн танилцуулга хийсэн. Мөн Хоршоо 152 фейсбүүк хуудсаар дамжуулан Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг хөтөлбөрт хамрагдсан хадгаламж, зээлийн хоршоодын гишүүдэд хүргэж, сурталчлан ажилласан.



3.3 ЗАЛУУЧУУДЫГ ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ ТӨСӨЛ

“Залуучуудын хөгжил, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хувь хүний хөгжлийн цогц сургалтын хөтөлбөр боловсруулан, залуучуудыг хамруулж, хөдөлмөрт бэлтгэх ажлын байраар ханган дэмжлэг үзүүлэх” зорилтын хүрээнд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан Монгол улсын иргэн 15-34 насны ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа залуучуудыг хамруулахаар залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төслийг боловсруулж, Засгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 58 дугаар тогтоолоор батлуулсан.

Төслийг 2021-2024 онуудад хэрэгжүүлэх бөгөөд энэ жил 8 ээлжээр 2390 оролцогчийн хамруулан тус байгууллагын 8 албан хаагч 14 хоногоор хотхонуудад байрлан судалгааны багын ахлагчаар ажиллаа.



Бүртгэлийн үйл ажиллагаа

E-mongolia системд Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төсөлд оролцохоор бүртгүүлсэн залуучуудын мэдээллийг [Esurgalt-a3458.web.app](https://www.esurgalt-a3458.web.app) сургалт бүртгэл, үнэлгээний системд хотхон болон бүлэг хуваарилалтыг программ автоматаар нас, хүйс, харьяалал, боловсролын түвшинг харгалзан хийсэн ба үүний дагуу Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын албан хаагчид Үндэсний батлан


хамгаалахын их сургуулийн гадна талбайд бүлэг хуваарилалтын дагуу оролцогчдыг сургалтын хотхонууд руу хуваарилах ажлыг 8 удаа зохион байгуулж ажиллалаа.

Бүртгэл үйл ажиллагаа нь 10 хэсгээс бүрдсэн.

1. Сургуулийн шалганаар тухайн иргэний ирцийг бүртгэх, таних
2. Эрүүл мэндийн асуумж бөглөх
3. Түргэвчилсэн шинжилгээ өгөх
4. Шинжилгээний хариу esurgalt программд шивэх
5. Бүлгийн хуваарилалтыг тулгах
6. Эерэг гарсан болон ирээгүй хүний оронд нөөцөд бүртгэлтэй иргэнийг бүлэгт нэмж оруулах
7. Сургалтын гэрээг тулгах, гэрээг шинээр байгуулах
8. Эерэг гарсан болон шар бүсийн бүртгэл хийх
9. Автобусанд иргэдийг хуваарилан хотхон руу явуулах
10. Судалгааны багийн ахлагч болон Батлан хамгаалах яамны харьяа газрын цэргийн албан хаагчид оролцогчдыг хариуцан хотхонд хүргэх



Ээлж тус бүрээр харуулбал:



Оролцогч нарын буцсан шалтгааныг авч үзвэл нийт 75 оролцогч Ковид-19 эерэг тохиолдол болж оношлогдон эмнэлэгт хүргэгдсэн, мөн гэр бүлийн болон хууч өвчний улмаас буцсан.

Бизнес аялал

Төслийн вакумжуулсан сургалтад хамрагдсан залуучуудад бизнесийн байгууллага тэр дундаа бодит үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажлын байрны урьдчилсан төсөөлөлтэй болж бараа бүтээгдэхүүнтэй танилцах, мэдээ, мэдээллээр хангуулах зорилготой 8 ээлжийн үйлдвэртэй танилцах аяллыг, Эйч ар клуб ТББ хамтран зохион байгуулсан. Оролцогчид

бүлгийн удирдагчдаа төслийн 5 дахь өдрөөс өмнө сонголтын хуудсаар аялалд оролцохоо илэрхийлсэн ба төслийн 7 дахь өдөр аялалд оролцсон. Оролцогчдод мэдээллийг ижил өгч, санал авах хугацааг хатуу баримталж, оролцогчдыг тэгш хамруулах зарчмыг баримталж ажиллалаа.

8 ээлжид нийт 716 оролцогчийг давхардсан тоогоор 10 үйлдвэртэй танилцуулах ажлыг зохион байгуулсан. Үйлдвэрлэлтэй танилцах аялалд хамрагдсан оролцогчид амжилттай ажиллаж буй ажилтны туршлага, байгууллагын онцлог, үйлчилгээний стандарт, соёл, амжилтад хүрсэн түүх, ажлын байрны зохион байгуулалт, үйлдвэрлэлийн орчин нөхцөл, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн явцтай танилцаж, харилцан яриа өрнүүлсэн.

Нийт оролцогчдыг хүйсийн болон боловсролын түвшингээр харуулбал



Хамгийн их буюу 182 оролцогч Улаанбаатар хотоос оролцсон бол хамгийн бага нь буюу 6 оролцогч Говь-Алтай аймгаас оролцсон байна. Орон нутгаас хамгийн идэвхтэй оролцсон нь Дархан, Завхан, Баянхонгор, Увс, Хэнтий, Баян-Өлгий, Өмнөговь аймгууд байлаа.

Мөн 8 дугаар ээлжид 64 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдсанаас үйлдвэртэй танилцах аялалд 5 оролцогч хамрагдсан байна. Оролцогчид 24-31 насны 4 эрэгтэй, 1 эмэгтэй оролцогч байсан ба 4 оролцогч нь тэргэнцэртэй, 1 оролцогч бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй байсан.

Ажил олгогчтой хийх уулзалт

Сургалтад хамрагдсан залуучуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, ажил олгогчдоос ирүүлсэн нээлттэй ажлын байртай танилцах, 14 хоногийн сургалтын дараах дадлагаар ажиллах аж ахуйн нэгж байгууллагаа олох зорилготой төслийн сургалтын 12 дахь өдөр зохион байгуулагдахаар нэгдсэн удирдамжид тусгагдсан Ажил олгогчтой хийх уулзалт, хөдөлмөрийн яармагийг 8 ээлжид 8 удаа, Эйч ар клуб ТББ хамтран зохион байгууллаа. Нэгдсэн удирдамжид заасны дагуу 500-600 хүртэл сургалтын оролцогчтой хотхонд 40 ажил олгогч, 290-320 хүртэл оролцогчтой сургалтын хотхонд 20 ажил олгогчтой өдөрлөгийг зохион байгуулан ажилласан.

Өдөрлөгөөр ажил олгогч аж ахуйн нэгж байгууллага сул чөлөөтэй, шаардлагатай байгаа ажлын байранд хүний нөөцийн бүрдүүлэлт хийхээс гадна оролцогчдод Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын мэргэжилтнүүд, судалгааны багийн гишүүд, Эйч ар клуб ТББ-ын хүний нөөцийн менежерүүд, ажил олгогчид дадлагажих үйл ажиллагааны мэдээлэл зөвлөгөө өгч, дадлагын ажлын байранд бүртгэл хийн, гэрээ байгуулан ажилласан.

I-VIII ээлжийн 12 дахь өдөр зохион байгуулагдсан тус өдөрлөгт давхардсан тоогоор 192 ажил олгогч оролцохоор Үндэсний батлах хамгаалахын их сургууль дээр

шинжилгээнд хамрагдсанаас сөрөг гарсан 175 ажил олгогч, 7422 ажлын байрыг танилцуулж, 873 оролцогч өдөрлөгийн үеэр ажил олгогчтой дадлагажих гэрээ байгуулсан байна. Өдөрлөгт оролцсон ажил олгогчдыг үйл ажиллагааны чиглэлээр харуулбал:



Дадлагын үйл ажиллагааны мэдээлэл

Нийслэлийн хэмжээнд сургалтаар эзэмшсэн мэдлэг, чадвараа практикт үйл ажиллагаатай холбон бататган гүнзгийрүүлж, ажиглалт, судалгаа, боловсруулалт хийх чадвар, дадал эзэмших зорилгоор дадлагажих үйл ажиллагаанд **270** ажил олгогчтой хамтран ажиллаж, **752** оролцогч дадлагажсан ба **381** дадлагажигч байнгын ажлын байраар хангагдсан байна. Оролцоо төсөлд нийт **65** хөгжлийн бэрхшээлтэй иргэн, үүнээс **50** нийслэлийн харьяат иргэд оролцож, дадлагажих үйл ажиллагаанд 100 хувь хамрагдсан.


Төслийн 1-6 дугаар ээлжинд оролцогчийн дадлагын дэвтэр хэвлэгдэж ирээгүйн улмаас ажил олгогч болон дадлагажигч нарын бүрдүүлэх баримт олон байсан нь удаашралтай байлаа. Мөн ажил олгогчид дадлагажигчийг илүү цагаар болон шөнийн ээлжинд ажиллуулах, дадлагажигчийн ажлын чиг үүргийн ажил хийлгэхгүй гэх мэт хүндрэлтэй асуудал тулгарсан.

Олон дадлагажигч ажиллуулсан аж ахуй нэгж байгууллагууд хүний нөөцөө богино хугацаанд бүрдүүлж чадсан бөгөөд үйл ажиллагаагаа олон нийтэд хүргэж ажиллахад дадлагын ажил чухал үүрэг гүйцэтгэсэн тухай талархал илэрхийлж байлаа.

3.4 СУДАЛГАА


Тус газар нь 2021 оны байдлаар дараах судалгаануудыг хийж, үр дүнг нэгтгэж ажиллалаа.

1. Нийслэлийн хэмжээнд 2021 оны 01 дүгээр сарын 11-ны өдрөөс эхлэн Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулж, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж байгаатай холбогдуулан, Нийслэлийн Засаг даргын А/06 тоот захирамжид үйл ажиллагааг нь хязгаарлах 18 чиглэлийг баталсан. Эдгээр 18 чиглэлийн үйл ажиллагаа нь зогссон аж ахуйн нэгж, иргэний судалгааг хийсэн.




Судалгаанд хамрагдсан 2182 аж ахуйн нэгж, байгууллагаас худалдааны төв 9%, бөөний худалдааны төв 29%, нийтийн хоол 21%, ахуйн үйлчилгээ 32%, сургалт 9%-ийг эзэлж байна. Бөөний худалдаа, ахуйн үйлчилгээний чиглэлээр лангуу ажиллуулдаг иргэд илүү их өртөж байгаа нь харагдаж байна.

2. Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа холбоодын мэдээллийг цахим систем ашиглаж авснаар 63 ТББ-ын холбогдох мэдээллийг цуглуулсан. Үүний 31 холбоодтой утсаар холбогдож, хөл хорионы үед ажлын байрны нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудал болон хөдөлмөр эрхлэлттэй холбоотой санал хүсэлтийг авч ажилласан.
3. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй 64317 аж ахуйн нэгж, байгууллагыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар болон дүүргээр нь нэгтгэн гаргасан. Судалгааг салбараар нь авч үзэхэд: бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар хамгийн их буюу 44%, Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбар хамгийн бага буюу 0,05% байна. Үйл ажиллагаа явуулж буй байршлаар нь үзэхэд: хамгийн их аж ахуйн нэгж, байгууллагатай нь Сүхбаатар дүүрэг, хамгийн бага аж ахуйн нэгж, байгууллагатай нь Багахангай дүүрэг байна.
4. Нийслэлийн нутаг дэвсгэрт хүнсний дэлгүүр, томоохон зах, худалдааны төв, үсчин, гоо сайхны үйл ажиллагаа явуулдаг 9010 аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагааг салбар, дүүргээр нь гаргасан.




Графикаас харахад Багануур дүүрэгт 163, Багахангай дүүрэгт 17, Баянгол дүүрэгт 1303, Баянзүрх дүүрэгт 2470, Налайх дүүрэгт 206, Сүхбаатар дүүрэгт 1055, Сонгинохайрхан дүүрэгт 1475, Хан-Уул дүүрэгт 1226, Чингэлтэй дүүрэгт 1095 аж ахуйн нэгж, иргэн үйл ажиллагаа эрхэлж байна. Хүнсний дэлгүүр 3100, түргэн үйлчилгээний цэг 1002, үсчин 2751 үйл ажиллагаа эрхэлж байгаагаас үзэхэд хувиараа хөдөлмөр эрхлэгч ихэнх хувийг эзэлж байна. Иргэд цар тахлын үед эрсдэлтэй нөхцөлд үйл ажиллагаа явуулж байна.

- “Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ”-нд хамрагддаг зорилтот бүлгийн 18-34 насны 5254 иргэнээс “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл”-д хамрагдах, эсэх тухай судалгааг авснаар Баянзүрх дүүргээс 314 иргэн, Сонгинохайрхан дүүргээс 465 иргэн вакуумжуулсан сургалтад хамрагдах боломжтой гэсэн үр дүн гарсан.




- Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу авто замын түгжрэлийг сааруулах зорилгоор “Их тойруу”-гийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй 5 дүүргийн 29 хорооны төрийн захиргааны 233 байгууллагын 15611 албан хаагч, хувийн хэвшлийн 7512 аж ахуйн нэгжийн 32979 ажилчин, 50 зах худалдааны төвийн 10058 ажилчин, 53 үзвэр үйлчилгээний газрын 1781 ажилчин, 3093 үйлчилгээний байгууллагын 13108 ажилчин, 31 их дээд сургуулийн 2505 багш, ажилчин, 77 **ЕБС**-ийн 5635 багш ажилчин, 109 цэцэрлэгийн 2782 багш ажилчин нийт 11158 аж ахуйн нэгж, байгууллагын 84459 ажилчин, албан хаагчдын тоон мэдээллийг холбогдох байгууллагуудаас авч тус тус нэгтгэн ажилласан.


7. Засгийн газрын 58 дугаар тогтоолын дагуу залуучуудад эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, эх оронч үзлийг төлөвшүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх замаар хөдөлмөрт бэлтгэж, хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхлыг бий болгох зорилготой “ОРОЛЦОО” төслийн хүрээнд 2021 оны 09 дүгээр сарын 02-ний өдрөөс 11 дүгээр сарын 7-ны өдрийг хүртэлх хугацаанд 1-8 дугаар ээлжээр зохион байгуулж нийт 2367 залуучуудыг хамруулсан. Эдгээр иргэдийг ээлж тус бүр, нас, хүйсээр нь авч үзвэл:



Графикаас үзэхэд нийт оролцогчдын 55.8 хувь нь 18-25 насны залуучууд байгаа ба “Оролцоо” төсөлд залуучууд идэвхтэй оролцсон нь харагдаж байна.



Үүнээс 1423 буюу 60.1 хувь нь эмэгтэй байна. Нийт 2367 оролцогчдын 1663 буюу 70.2 хувь нь орон нутгийн иргэд, 704 буюу 29.8 хувь нь нийслэлийн иргэд хамрагдсан байна. Оролцогчдын 23.8 хувь нь дээд, 49.3 хувь нь бүрэн дунд боловсролтой иргэд хамрагдсан үзүүлэлт гарч байна.



2021 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн байдлаар Нийслэлийн хэмжээнд 526 оролцогч ажил олгогч байгууллагатай гэрээ байгуулан дадлага хийж, 310 оролцогч байнгын ажлын байртай болсон үр дүнтэй байна.

3.3. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас жил бүрийн 04 дүгээр сарын 28-ны өдрийг “Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэлхийн өдөр” болгон олон улсын хэмжээнд 2003 оноос хойш 18 дахь жилдээ тэмдэглэж байна.



Энэ жил “Хямралыг урьдчилан харж бэлтгэлтэйгээр даван туулья - ХАБЭА-н тогтолцоог бэхжүүлье” урианы дор “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян -2021” арга хэмжээг зохион байгуулж, хийх ажлын төлөвлөгөөг гарган, холбогдох арга хэмжээг коронавирус /ковид-19/-тэй холбогдуулан нэг дор олон хүн цуглуулахгүй байхад анхаарч, цахим орчинд хууль тогтоомж, дүрэм, журмыг танилцуулах, соён гэгээрүүлэх ажлыг хүргэн ажиллалаа. Үүнд:

Байгууллагын албан хаагчдад Ковид-19 цар тахлаас үүдэлтэй хямралыг даван туулах, түүнд хариу арга хэмжээ авах ажлын талаар зөвлөгөө, мэдээллийг тогтмол өгч “Стрессийг даван туулах”, “Ажлын байранд Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх” зэрэг сэдвүүдийн хүрээнд мэргэжлийн байгууллага, мэргэжилтний зөвлөгөө, мэдээллийг түгээн ажилласан.



Нийслэлийн Засаг даргын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аян зохион байгуулах тухай” 2021 оны А/291 дүгээр захирамжийн дагуу Нийслэлийн ажил олгогч эздийн холбоотой хамтран “Ковид-19 цар тахлын үед аюулгүй ажиллах зааварчилгаа, стандарт зөвлөмж” бүхий гарын авлага 4,000 ширхэг, ханын календарь 5,000 ширхэгийг тус тус хэвлүүлэн тараасан.

Нийслэлийн Улаанбаатар хотын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төв зэрэг газруудтай хамтран нийт 5 удаагийн 384 зөвлөлийн гишүүн, салбарын ажилтан, албан хаагчдыг хамруулан чадавхжуулах мэдлэг мэдээлэл олгох цахим сургалтыг зохион байгуулсан.



Мөн арга хэмжээний хүрээнд хөдөлмөрийн харилцааны маргаан, хөдөлмөрийн гэрээ, хамтын гэрээ болон бусад холбогдох асуудлаар 14 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

3.4. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар /хэрэгжилт/
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	36	36	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас зохион байгуулсан 4 цагаас дээш хугацааны 36 удаагийн сургалтад байгууллагын нийт албан хаагчдыг бүрэн хамруулсан. Тус газар нь 20 албан хаагчтай /эмэгтэй 15, эрэгтэй 5/ бөгөөд тайлант хугацаанд давхардсан тоогоор 119 албан хаагч /эмэгтэй 81, эрэгтэй 38/ тус сургалт, арга хэмжээнүүдэд хамрагдсан байна.
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	30	30	
			Мэргэшүүлэх сургалт	5	5	
			Туршлага солилцох арга хэмжээ	1	1	
			Бусад	-	-	
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	20	20 /давхардсан тоо 119/	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	15	15 /давхардсан тоо 81/	
			Эрэгтэй албан хаагч	5	5 /давхардсан тоо 38/	
			Удирдах албан тушаалтан	4	4	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	16	16	
1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	100%			
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	1	2	БНХАУ-аас МУ-д суугаа ЭСЯ-наас зохион байгуулсан “Хөгжиж байгаа орнуудын төрийн үйлчилгээ ба ядуурлыг бууруулах нь” олон улсын цахим сургалт, төрийн албан зөвлөлөөс зохион байгуулсан “Зөөлөн ур чадварыг хөгжүүлэх туршлага” сэдэвт цахим сургалт /АНУ-ын Allstate компанийн туршлага солилцох/-д тус тус нийт 5 албан хаагчийг хамруулан чадавхжуулсан.
		2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	1	5	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	1	4	
			Эрэгтэй албан хаагч	0	1	
			Удирдах албан тушаалтан	0	1	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	1	4	
2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	20-оос дээш хувь	25%			
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	2,450,050	2,450,050	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд 2021 оны 11 дүгээр сарын байдлаар зарцуулсан зардлын хэмжээ 2,450,050 төг байна.
		3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	10%	Тус газар нь 20 орон тоотой бөгөөд албан хаагчдын 10%-д шилжилт хөдөлгөөн хийгдэж, 90% нь тогтвор суурьшилтай ажиллаж байна. Тус газрын 2 албан хаагч өөр байгууллагад шилжин ажиллах хүсэлт гаргасны дагуу Газрын даргын 2021 оны Б/02, Б/29 дүгээр тушаалуудаар ажлаас чөлөөлсөн.
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
4.	Цалин хөлс, шагнал,	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан	100%	36.8%	Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын 2021 оны

	урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх		зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь			үйл ажиллагааны нийт төсөв 6,345,050,600 төгрөг ба үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 296,902,500 төгрөг зарцуулахаар батлагдсан. 2021 оны 11 дүгээр сарын байдлаар 240,150,197 төгрөг зарцуулсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд төсөвлөсөн нийт дүнгийн 81%, байгууллагын нийт төсвийн 3.7%-ийг тус тус эзэлж байна.
		4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	24,200,000	10,103,500	Нэг албан хаагчид хоногт хоолны 4500 төгрөг, унааны 500 төгрөгийн хөнгөлөлтийг олгодог ба 2021 онд нийт 20 албан хаагчид 22,183,700 төгрөг зарцуулахаар батлагдсан. 2021 оны 11 дүгээр сарын байдлаар 18,924,371 төгрөг зарцуулсан байна.
5.	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш		Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгыг жишиг загварт нийцүүлэн боловсруулж, нийт албан хаагчдаас авсан бөгөөд санал асуулгын дүн дунджаар 81% байв.
6.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш	2	Ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн Мэргэжлийн өвчин судлалын газарт тус байгууллагын 19 албан хаагчийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, 8 төрлийн шинжилгээнд хамруулсан. Мөн цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан Нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүсэлт гаргасны дагуу Ковид-19 илрүүлэх PCR шинжилгээнд байгууллагын нийт албан хаагчдыг зохион байгуулалттайгаар хамруулсан.
		6.2.	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	100%	Тус шинжилгээнд байгууллагын нийт албан хаагчид сайн дурын үндсэн дээр хамрагдсан болно.
7.	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	119,415,500	109,215,874	"Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2021 оны төлөвлөгөө"-г батлан хэрэгжүүлсний дагуу тайлант хугацаанд албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 1,464,600 төгрөгийг зарцуулсан.

3.5 ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

Нийслэлийн хэмжээнд төрийн үйлчилгээний www.eservice.ulaanbaatar.mn дэд системийг бүрэн нэвтрүүлсэнтэй холбогдуулан тус Газрын хүний нөөц, цагийн бүртгэл, үүрэг даалгавар, өргөдөл гомдол, санал хүсэлт, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, төсөв санхүү, албан бичгийн шийдвэрлэлт зэрэг бүхий л үйл ажиллагаа erp.ulaanbaatar.mn системээр хэрэгжиж байна.

Архивын ажлын хүрээнд:

✓ Архивын ажлын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж холбогдох албан тушаалтнаар хэлэлцүүлэн батлуулсан.

✓ Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байгууллагын зохион байгуулалтын нэгжүүдээс хүлээн авах, бүртгэх, ангилан төрөлжүүлэх, бүрэн бүтэн байлгах, удирдлагын үйл ажиллагаанд ашиглуулах, байнга хадгалах баримтыг сонгон, байгууллагын архивд хүлээн авсан. Нийт 147 хадгаламжийн нэгж байгууллагын архивд хүлээн авснаас байнга хадгалах 45, түр хадгалах 96, 70 жил хадгалах 6 хадгаламжийн нэгж байгаа бөгөөд данс, бүртгэл хөтлөн, ангилан төрөлжүүлсэн байна.

✓ 2020 оны газрын үндсэн үйл ажиллагааны 59 тушаал, хүний нөөцийн 61, нийт 120 тушаалыг Archive edoc программд шивэн цахим архив үүсгэсэн байна.



Өргөдөл, гомдол шийдвэрлэх ажлын хүрээнд:

✓ Газрын хэмжээнд нийт 33 /өссөн дүн/ өргөдөл ирснээс хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэгдсэн байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног 8 цаг 6 минут байна.

✓ Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ, тайланг улирал бүр гарган Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлсэн.

Албан хэрэг хөтлөлтийн хүрээнд:

Газрын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр /А/ 30 /өссөн дүн/, хүний нөөцийн чиглэлээр /Б/ 34 /өссөн дүн/ нийт 64 тушаал гарсныг дугаар өгч, бүртгэн эх хувийг зориулалтын хатуу хавтсанд хадгалж байна.

✓ Газрын хэмжээнд нийт 623 /өссөн дүн/ албан бичиг ирснээс 278 нь хариутай бичиг, 345 нь хариугүй бичиг байна. Хариутай бичгийг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн.

✓ Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 99, хариугүй бичгийн хаалтын хувь 100, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 99%-тай байна.

✓ Тус газрын явсан албан бичгийн боловсруулалтад монгол хэл бичгийн дүрмийн дагуу баримт бичгийн стандартыг мөрдөж бүртгэн хариу ирүүлэгчийн байдалд хяналт тавьж ажилласан ба 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт **267** /өссөн дүн/ албан бичгийг цахимаар боловсруулан холбогдох газруудад хүргүүлсэн.

Дотоод ажлын хүрээнд:

✓ 2021 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөний 40 удаагийн 92 орчим үүрэг даалгаврын биелэлтийг гарган Нийслэлийн засаг даргын тамгын газрын Ulaanbaatar.mn сайтад тайлагнасан.

✓ Албан хэрэг хөтлөлтийн Edoc системийг ашиглан албан хаагчдад ирсэн бичгийн шийдвэрлэлт болон явуулж байгаа албан бичигт тухай бүрд хяналт тавин ажиллаж байна.

✓ Шийдвэрлэсэн албан бичгийг Edoc системийн хяналт цэсээр дахин баталгаажуулж үг үсэг, найруулгын алдааг хянан шалгасан.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

4.1. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр улс, орон нутгийн хэмжээнд баримталж буй бодлого шийдвэрүүд, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, зохион байгуулж буй арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг байгууллагын албан ёсны мэдээллийн сувгууд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг тасралтгүй зохион байгуулж ажилласан.

Энэ хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа болон шинэ төрлийн коронавирус /Covid-19/-ийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар холбогдох байгууллага, албан тушаалтнуудаас гаргасан тогтоол шийдвэр, мэдээ, мэдээлэл болон хөдөлмөр эрхлэлтийн мэдээ, мэдээллийг байгууллагын албан ёсны www.ubbirj.ub.gov.mn цахим хуудас, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв” болон “Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар” фэйсбүүк хуудсуудаар тайлант хугацаанд **324** мэдээ мэдээллийг байршуулж, **852281** иргэнд, **131896** тусгай дугаарын www.smsservice.opensoft.mn/ үйлчилгээгээр **21590** иргэнд, цахим зуучлалын үйлчилгээгээр **173** ажил олгогч, **3105** иргэнд, UB JOB аппликейшнаар **123** иргэнд, нийт **659659** иргэнд хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээ, мэдээллийг хүргэсэн байна.

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал		
1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Хувь хүний нууцын болон Байгууллагын нууцын тухай, Төрийн нууцын тухай хуулиудын хэрэгжилтийг ханган, байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, зохион байгуулалтын бүтэц, албан хаагчдын ажлын байрны жагсаалт зэрэг 100 гаруй нэр төрлийн мэдээллүүдийг байршуулан тухай бүр шинэчлэн ажиллалаа.
2	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын үйлчилгээ, захидал, харилцааны асуудлыг Дотоод ажил, архив, бичиг хэрэг, даргын туслах гүйцэтгэн ажиллаж байна. Байгууллагын цахим сайт, шилэн дансанд Газрын даргын “Б” тушаалууд, байгууллагын бүтэц, хүний нөөц, албан хаагчдын албан тушаал, и-мэйл хаяг, холбоо барих утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь зэрэг мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод байршуулан, тухай бүр шинэчлэн ажиллалаа. 2021 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын www.ubbirj.ub.gov.mn цахим хуудсаар хэрэглэгчдэд хөдөлмөр эрхлэлтийн газрын танилцуулга, видео, хөдөлмөрийн хууль тогтоомж, хэрэгжүүлж буй хөтөлбөр цаг үеийн мэдээ мэдээлэл, нийтлэл, хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой зар мэдээлэл зэрэг нийт 324 гаруй мэдээллийг оруулан 852281 хандалт авсан байна.
3	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн танилцуулга, бусад хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээ, өдөрлөг яармаг, хэлэлцүүлгийн талаар мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулж ажиллалаа. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ,

		хөтөлбөрт хамрагдагсдад шаардагдах баримт, бичгийн бүрдлийн жагсаалтыг цахим хуудсанд байршуулсан.
4	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг бэлтгэн байгууллагын ubbirj.ub.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбартаа тогтмол байршуулан ажиллаж байна. 2021 онд Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм болон холбогдох бусад хууль, эрх зүйн актуудыг шинэчлэн байршуулсан. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.9 дэх заалтын дагуу 100 ба түүнээс дээш ажилтантай хувийн хэвшлийн байгууллагуудаас КОВИД-19 цар тахлын үед хэвийн ажиллаж байгаа салбарын 150 аж ахуйн нэгж байгууллагатай холбогдож, Засгийн газрын 2020 оны 228 дугаар тогтоол болон оюутан суралцагчид, цагийн ажилтан ажиллуулах журмыг танилцуулж, цагийн ажлын байр зарлагдаж байгаа эсэхийг тодруулж мэдээлэл солилцож, хамтран ажилласан.
5	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дүрэм болон холбогдох бусад хууль, эрх зүйн актад үндэслэн Газрын даргын 2021 оны А/12 дугаар тушаалаар байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн баталж, байгууллагын албан ёсны www.ubbirj.ub.gov.mn цахим хуудсанд байршуулан нийт албан хаагчдад танилцуулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. 2021-2024 оны Нийслэлийн Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн гишүүдийг мэдээллээр ханган, тус ажлын хүрээнд Мандатын шинжилгээ хийхэд хэрэглэгдэх мэдээллийг холбогдох хүснэгтийн дагуу 5 удаа боловсруулан НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлсэн.
6	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавигдах MNS:6620-2016” стандартын дагуу хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж буй үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох, зохион байгуулалтын арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлээ. Үүнд: Ажил хайгч иргэн, ажил олгогчид зориулсан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хөнгөвчлөх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор https://job.opensoft.mn/ бүртгэлийн системтэй холбосон UB JOB гар утасны аппликейшнийг 2020 оны 01 дүгээр сараас үйлчилгээнд нэвтрүүлсэн. Энэхүү аппликейшн нь ажил хайгч иргэд бүртгүүлэх, сонгосон хайлтаар мэдээлэл авах, ажил олгогч сул чөлөөтэй ажлын байрны мэдээллээ бүртгүүлэх зэрэг үйлчилгээг IOS, Android үйлдлийн системтэй бүх төрлийн гар утас, планшетаар ажлын цаг үл харгалзан авах, мэдээллийг аюулгүй, түргэн шуурхай солилцох боломжийг олгож байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар UB job аппликейшнээр нийт 123 иргэн үйлчилгээ авсан байна.
7	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж	Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлөөс баталсан хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрх бүхий хөдөлмөрийн бирж, сургалтын байгууллагатай хамтран ажиллаж, сургалтын байгууллагуудын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг мэдээллийн самбартаа байрлуулан, сурталчилж байна.

	байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;	
8	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Тус байгууллага нь тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодоггүй болно.
9	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	<p>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс 2021-2022 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 5 хөтөлбөр, 2 төсөл баталсан. Тус байгууллага нь нийслэлийн хэмжээнд 3 хөтөлбөрийн 5 арга хэмжээг дүүргүүдийн ХХҮХ-тэй хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн Оюутан залуучуудыг цагийн ажилд зуучлах; Шилдэг старт-ап залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ - “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-ийн Хөдөлмөр эрхлэлтийн танхимын сургалт зохион байгуулах; Хөдөлмөрт бэлтгэх /АМЧБО/ - “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийн Нийтийг хамарсан ажил зохион байгуулах; Гэрээт малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байна. <p>Батлагдсан төсөл, хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг байгууллагын ubbijrj.ub.gov.mn цахим хуудсанд байршуулав.</p>
Хэсгийн дундаж хувь:		
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;		
1	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газарт 2021 онд гарсан 3 сул орон тоог нөхөх зорилгоор төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулах хүсэлтийг холбогдох мэдээллийн хамт дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнээр тус хугацаанд тусгай шалгалт зохион байгуулагдаагүй тул шалгалт зохион байгуулагдах үед мэдээллийг ил тод хүргэх талаарх тайлбарыг байгууллагын ubbijrj.ub.gov.mn цахим хуудсанд байршуулав.
2	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг 2021 онд байгууллагын ubbijrj.ub.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт шинэчлэн байршуулав.
3	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	<p>Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг байгууллагын ubbijrj.ub.gov.mn цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Журмын 4 дүгээр хавсралтаар “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг тайлагнах хүснэгтийг баталсан.</p>


4	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	<p>Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах зорилгоор дараах мэдээллүүдийг байгууллагын ubbijrj.ub.gov.mn цахим хуудсанд байршуулав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” - “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2021 оны төлөвлөгөө” - “Ажилтан, албан хаагчдыг 2021 онд чадавхжуулах сургалтын төлөвлөгөө” - Байгууллагын бүтэц, албан хаагчдын нэр, албан тушаал, өрөөний дугаар, цахим хаяг, утасны дугаар
5	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	<p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 8 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн тайлангийн загвар”, 9 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх аргачлал”, 10 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний хуудсын загвар”-ыг тус тус байгууллагын ubbijrj.ub.gov.mn цахим хуудсанд байршуулав.</p>
Хэсгийн дундаж хувь: 90%		
Хэрэгжилтийн дундаж хувь: 90%		

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

5.1. ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв, Цагийн ажлын биржээр дамжуулан байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах, нийслэлийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор салбарын болон орон нутгийн холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд, дүүрэг, хороод, албан бус салбартай уялдаа холбоотой хамтран ажиллаж, хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлэхэд чиглэсэн олон талт ажлыг зохион байгууллаа. Тус ажлын хүрээнд:

- ✓ Тайлант хугацаанд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд төр, хувийн хэвшлийн **1145** ажил олгогч байгууллагатай хамтран ажиллаж, нийт 13525 ажлын байрны захиалгыг төвлөрүүлж, олон нийтэд мэдээлж ажилласан.
- ✓ <http://imis.gov.mn/>, <https://job.opensoft.mn/> системүүдийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Мэдээллийн технологийн төв, “Опенсофт” ХХК-тай системийн хэвийн ажиллагаа, шаардлагатай хөгжүүлэлт, сайжруулалтын чиглэлээр уялдаа холбоотой ажиллаж байна.
- ✓ Хөдөлмөрийн цахим яармаг 2021 арга хэмжээний хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Экспо Монголиа ХХК, Эйч ар клуб ТББ, Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, НҮБ-ийн дэргэдэх Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага болон илтгэл мэдээлэл танилцуулга хийсэн 50 илтгэгч, түүний байгууллагуудтай хамтран ажиллалаа.
- ✓ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаарх мэдээлэл болон Хөдөлмөрийн цахим яармаг 2021 арга хэмжээний мэдээллийг Нийслэлийн Хэвлэл мэдээллийн алба, Монголын радио, UBS TV, TV8, TV5, MN25, TV6, ETV, NTV телевиз, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайт, байгууллагын албан ёсны мэдээллийн сувгуудаар дамжуулан иргэд, олон нийтэд тухай бүр хүргэлээ.



- ✓ Хөдөлмөрийн цахим яармаг 2021 арга хэмжээний хүрээнд Нэкт электроникс ХХК, Болд төмөр ерөө гол ХХК, Номин холдинг ХХК, Тэсо корпораци, Алтан жолоо трейд ХХК, Интерактив гурпп, Нью прогресс групп ХХК, MSDI pro HRC ХХК, MSM групп ХХК, Макс хүнс ХХК, Скай хайпермаркет ХХК, Боса холдинг ХХК, Монголын хүний нөөцийн институт, Монголын хүний нөөцийн мэргэшсэн менежерүүдийн холбоо, СЭЗИС, Юнител групп, Монос эмийн үйлдвэр гэх мэт ажил олгогч болон судалгаа шинжилгээний байгууллагуудтай хамтран ажилласан.

- ✓ “Ажил мэргэжил судлалын үндэсний хүрээлэн”-тэй хамтран ажиллах санамж бичгийг 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдөр “Шилжин ирэгсдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар тэдэнд нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх төр болон хувийн хэвшлийн байгууллагуудын сүлжээг буй болгож чадавхыг бэхжүүлэх зорилгоор байгуулсан.




- ✓ Швейцарын хөгжлийн агентлаг Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслөөс Хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг залуучуудад хүргэх, хамтран ажиллах талаар санал солилцох уулзалтыг 2021 оны 05 дугаар сард зохион байгуулж, уулзалтын үр дүнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих загвар төвийг байгуулахаар болсон. Үүний хүрээнд загвар төвийн тоног төхөөрөмж, засвар, тавилга эд хогшлын мэдээллийг гарган төслийн захиргаанд хүргүүлсэн.



- ✓ Европын холбооны санхүүжилттэй НҮБ-ын дэргэдэх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн баг 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн үйл ажиллагаатай танилцаж, Хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг үзүүлсэн тайлантай танилцаж, хамтран ажиллах талаар санал солилцсон. Тус уулзалтад Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга Г.Ганзориг болон дэмжих төвийн мэргэжилтнүүд оролцлоо.




- ✓ Биеийн тамир спортын улсын хорооноос ирүүлсэн удирдамжийн дагуу байгууллагын албан хаагчдын биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөний энгийн дасгал болох алхалт, гүйлтээр хичээллэхэд уриалах, таниулах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, дасгал хөдөлгөөн тогтмол хийж, эрүүл амьдралын дадал хэвшилд суралцах зорилгоор зохион байгуулсан “Эрүүл мэндийн цахим гүйлт 2021” арга хэмжээнд нийт албан хаагчид идэвхтэй оролцсон.




- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Төрийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэх нь” ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтыг 2021 оны 03, 04, 05 дугаар саруудад үе шаттайгаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй **58** иргэнийг хамрууллаа.



- ✓ Олон Улсын Хөгжлийн Агентлаг “Best” хөтөлбөрөөс зохион байгуулсан “Төсөл бичих аргачлал” **16** цагийн цахим сургалтад 2021 оны 02 дугаар сарын 18-наас 25-ны өдрүүдэд **5** хадгаламж зээлийн хоршооны **10** гишүүн хамрагдсан.
- ✓ Нийслэлийн Засаг даргын орлогчид Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын үйл ажиллагаатай танилцаж, хөдөлмөрийн эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээг сайжруулах, шинэ шинэлэг үйлчилгээг туршин нэвтрүүлэх, тулгамдаж асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам гэх мэт олон талыг хамарсан уулзалтыг 2021 оны 05 болон 11 сард 2 удаа Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газарт зохион байгуулж, албан хаагчдын санал сэтгэгдлийг сонслоо.



- ✓ Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн хурлыг зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр 2021 оны 05 дугаар сарын 04-ний өдөр цахимаар зохион байгууллаа. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2021-2022 оны хөтөлбөр”-ийг баталсан. Үүний дагуу улсын хэмжээнд 5 хөтөлбөр хэрэгжихээс Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар нийслэлийн хэмжээнд 3 хөтөлбөр хэрэгжүүлэхээр тусгагдсан.



- ✓ Монгол улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн тэрбум мод тарих санаачилга, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Нийслэлийн Засаг даргын тамгын газраас баталсан “Мод тарих өдөр, байршлын хуваарь”-ийн дагуу 2021 оны 10 дугаар сарын 09-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн 24 дүгээр хороо, Баруун салааны Бумбатын рашаанд 8 албан хаагч, Налайх дүүргийн Цэцэрлэгт хүрээлэнд 5 албан хаагч тус тус 2 байршилд 50 ширхэг мод тарив.



5.2. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙЖ АЖИЛЛАСАН ТУХАЙ


Бодлогын болон захирамжлалын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын 2017 оны А/121 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар тушаалаар батлагдсан журмууд, үнэлэх аргачлалын дагуу үнэлж дүгнэв. Мөн дээрх захирамжлалын баримт бичгүүдийг үндэслэн тус газрын хэлтсүүдийн гүйцэтгэлийн тайланд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийн ажиллаж байна.

2021 онд 15 заалт бүхий хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөө, тус байгууллагын 2021 оны Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн болон санхүүгийн үйл ажиллагаанд Нийслэл дэх төрийн Аудитын газраас өгсөн зөвлөмж, дүгнэлтийн дагуу гүйцэтгэл сайжруулах хариу арга хэмжээний төлөвлөгөө зэргийг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар тус байгууллагад хяналтын байгууллагуудаас тавигдсан акт, албан шаардлага байхгүй болно.

5.3 СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

1. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн “Оюутан залуучуудыг цагийн ажилд зуучлах” арга хэмжээний хүрээнд Google form апплейкшн ашиглан Их, дээд сургууль, коллежийн оюутнуудаас хичээлийн бус цагийн ажил эрхэлдэг эсэх талаар сэтгэл ханамжийн судалгаа авсан бөгөөд тус судалгаанд 850 оюутан хамрагдсан байна.

Судалгаанд хамрагдсан нийт залуучуудаас нас хүйс, суралцаж буй сургууль, хичээлийн бус цагаар хөдөлмөр эрхлэлт, ажлын цаг, ажил хийх болсон шалтгаан, хэдэн төгрөгийн цалин авдаг талаар асуухад: Судалгаанд хамрагдсан нийт залуучуудын 48% нь эрэгтэй, 52% нь эмэгтэй ба суралцаж буй сургуулиар нь авч үзвэл 27% нь ХААИС, 29% нь Хүрээ дээд сургууль, 12% нь Төмөр замын дээд сургууль, 5.8% нь Техник технологийн дээд сургууль, 11.2 % нь МУБИС, 3.1% нь ШУТИС, 0.6% нь МУИС, 10% нь Монгол Солонгосын политехникийн коллеж, 0.8% нь Үйлдвэрлэл Урлалын политехникийн коллеж, 0.5% нь Барилгын политехникийн коллежийн оюутнууд байна.



Хөдөлмөр эрхэлдэг талаар авч үзвэл хичээлийн бус цагаар 43.8% нь ажил хийдэг, 56.2% нь ажил хийдэггүй гэж хариулсан ба хөдөлмөр эрхэлдэг залуучууд ямар чиглэлээр ажилладаг талаар авч үзвэл 78.3% нь үйлчилгээний ажил /худалдагч, бараа өрөгч, касс, ачигч, зөөгч, бармен, угаагч, бэлтгэгч, туслах ажилтан, гоо сайханч, хүүхэд асрагч г.м/, 15% нь барилгын ажил, 2.2% нь авто угаалгын газар, 4.5% нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг гэж хариулжээ.

Хөдөлмөр эрхэлдэг залуучуудын 32.2% нь 8-12 цагийн хооронд, 22.3% нь 12-17 цагийн хооронд, 42% нь 17-24 цагийн хооронд, 3.5% нь 24-03 цагийн хооронд ажилладаг ба ажил хийх болсон шалтгааныг авч үзвэл 8.6% нь ажлын туршлагатай болох, 12% нь ар гэрийн шаардлагаар, 72% нь хэрэглээгээ хангах зорилгоор, 28% нь бусад гэж хариулсан байна.

Хөдөлмөр эрхэлдэг залуучуудын цалинг авч үзвэл 51% нь 300.000 болон түүнээс доош, 28.4% нь 300.000-500.000, 12% нь 500.000-700.000, 8.3% нь 750.000 болон түүнээс дээш гэж хариулсан бөгөөд авсан цалин хэрэглээнд нь хүрэлцдэг эсэх талаар асуухад 32% нь тийм, 68% нь үгүй гэж хариулжээ.

Судалгааг дүгнэхэд цагийн ажил эрхэлдэг оюутнуудын 80% нь үйлчилгээний чиглэлийн ажил эрхэлдэг бөгөөд 42% нь хичээлийн бус цаг буюу 17-24 цагийн хооронд хөдөлмөр эрхэлж, 51% нь 300.000 болон түүнээс доош төгрөгийн цалин авч ажиллаж байна.


2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвөөр үйлчлүүлсэн иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч судалгааны дүнд дүгнэлт хийн, үйл ажиллагаагаа сайжруулахад

чиглүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд төвөөр үйлчлүүлсэн 110 иргэнийг судалгаанд хамруулсан.


Судалгаанд хамрагдсан нийт иргэдээс оршин суугаа дүүрэг, нас, хүйс, боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн орчин, нөхцөл, үйлчилгээний чанарын талаар асуухад:

- Иргэдийн 27.2% нь Баянзүрх, 11.2% нь Баянгол, 19% нь Сонгинохайрхан, 11.8% нь Сүхбаатар, 17.2% нь Хан-Уул, 11.8% нь Чингэлтэй, 1.8% нь Налайх, Багануур дүүргүүдэд тус тус оршин суудаг гэж хариулсан байна.
- Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 38% нь эрэгтэй, 62% нь эмэгтэй ба насны бүлгээр авч үзвэл 28.1% нь 18-25 насны, 25.4% нь 26-35 насны, 21.8% нь 36-45 насны, 16.3% нь 46-55 насны, 8.1% нь 56 дээш насны ажилгүй иргэн байна.
- Ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр харвал 22.7% нь дээд, 13.6% нь тусгай мэргэжлийн дунд, 7.2% нь техникийн болон мэргэжлийн, 48.1% нь бүрэн дунд, 6.3% нь суурь, 1.8% нь бага боловсролтой иргэд байна.

Ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 43.6% нь 1-3 сар, 18.1% нь 4-6 сар, 21.8% нь нэгээс дээш жил, 16.3% нь 1 жилийн хугацаанд ажилгүй байсан байна. Энэ хугацааг богиносгох, хөдөлмөрт бэлтгэх, ажилд оруулахад чиглүүлэх, сургалтад хамруулах, идэвхжүүлэх шаардлагатай байна.



- Ажиллахыг хүсэж буй салбарыг өмнөх онтой харьцуулахад үйлдвэрлэлийн салбар 12.2 хувиар, уул уурхайн салбар 3.3 хувиар, хөдөө аж ахуйн салбар 2 хувиар тус тус өссөн бол үйлчилгээний салбар 14 хувиар, барилгын салбар 3.7 хувиар тус тус буурсан байна. Цар тахлын эрсдэлтэй нөхцөлд зарим байгууллагын үйл ажиллагаа түр зогссоноос буурсан үзүүлэлттэй харагдаж байна.



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвөөр үйлчлүүлсэн иргэдийн орчныг 56.3 хувь маш сайн, 29.2 хувь нь сайн, 14.5 хувь нь дунд гэж хариулсан бол ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдсан иргэд нь үйлчилгээ үзүүлсэн албан хаагчийн харилцааны ур чадварыг 58.1 хувь нь сайн, 29.2 хувь маш сайн, 12.7 хувь нь дунд гэж дүгнэсэн байна.

5.4 ДҮГНЭЛТ, САНАЛ

Дүгнэлт: Үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн, цаг үеийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, цаашид ажлыг эрчимжүүлэх, сайжруулахад тасралтгүй анхаарч, төр-хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэн ажиллалаа.

Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг цахим хэлбэрээр зохион байгуулах чиглэлийг баримтлан, ажил олгогч байгууллага, ажил хайгч иргэдийг дэмжих, ажлын байр шинээр бий болох, хадгалах, боломж нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр санал, санаачилга гарган, холбогдох байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллаж байна.

2021 онд цар тахлын нөлөөллөөс үүдэлтэй ажиллах хүчний хомстолд орсон ажил олгогчдыг дэмжих чиглэлээр бодит олон ажлыг зохион байгуулж, хүний нөөцийн бүрдүүлэлтийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд зохион байгуулж, ажил хайгч иргэд болон ажил олгогчийн цаг завийг хэмнэх, чирэгдэлгүй үйлчилгээ авах, ажлын байранд шууд зуучлагдахад гол нөлөө үзүүлсэн үйл ажиллагаа байлаа. Тус үйл ажиллагааг ажил олгогчид таашаалтай хүлээж авч хамтран ажиллаж байлаа.

Санал:

- Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг бүртгэлжүүлж, тэдэнд шаардлагатай үйлчилгээ, зөвлөгөө, мэдээллийг хүргэх, татвар, нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулахад төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулан, үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

- Батлагдсан төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, явцын үр дүнд үнэлгээ хийхэд нийтийг хамарсан ажил болон хөдөлмөр эрхлэлтийн танхимын сургалт, үйлдвэрлэл дээрх сургалтын хэрэгцээ, шаардлага их байгаа нь харагдаж байгаа тул төсвийг батлах, нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;